МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)		Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр Хөтөлбөрийн зорилго: Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр		5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ: 5.1.1. улсын төсөв, олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; 5.1.2. гоц халдварт, халдварт, зооноз өвчин дэгдсэн онцгой байдлын үед улсын болон орон нутгийн төсөв; 5.1.3. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж; 5.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Мал эмнэлгийн ерөнхий газар 4 жил, 2018-2021 он		
			Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, МЭЭСБУЛ, УМЭАЦТЛ, Биокомбинат ТӨХХК		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 2.2.1: мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох Зорилт 2.2.2: мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах; Зорилт 2.2.3: мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах; Зорилт 2.2.4: мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох; Зорилт 2.2.5: мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх; Зорилт 2.2.6: малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, ур дүнг сурталчлан таниулах.		
5	Зардал	Төсөв (Нийт зардал)	25,359.5 сая төг		
		Үүнд:	Төсөв (2021 он)	Гүйцэтгэл	Хувь
		Бүрэлдэхүүн хэсэг 1	-	-	-
		Бүрэлдэхүүн хэсэг 2			
		Бүрэлдэхүүн хэсэг 3			
		Бүрэлдэхүүн хэсэг 4			
		Бүрэлдэхүүн хэсэг 5			

		Бүрэлдэхүүн хэсэг 6			
		Удирдлага			
		Нийт		**25,359.5 сая төг**	

6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ
	1-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 8-12 дүгээр хуудас.
	2-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 12-18 дугаар хуудас.
	3-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 18-23 дугаар хуудас.
	4-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 23-26 дугаар хуудас.
	5-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 26-31 дугаар хуудас.
	6-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 32-34 дүгээр хуудас.
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	**ДҮГНЭЛТ.** Хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээ 83.8, хөтөлбөрийн явцын хэрэгжилт 82.7 хувиар тус тус үнэлэгдэж, тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээтэйгээр төсөл дууссан байна. Салбарын хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн арга хэмжээг Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгасан нь тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээ авах гол нөхцөл болжээ. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох зорилтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ хамгийн бага /74.5%/ байна. **ЗӨВЛӨМЖ.** Үндэсний хөтөлбөр батлахаар бол хэрэгжүүлэх нэн шаардлагатай арга хэмжээг тусгайлсан төсөв хөрөнгөтэйгээр баталж, хэрэгжилтийг хангах чиглэлд бодлого төлөвлөгчид, Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох чиглэлийн арга хэмжээг үр дүнтэйгээр төлөвлөх, хэрэгжүүлэх чиглэлд хэрэгжүүлэгч байгууллага анхаарах шаардлагатай.
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалттай

9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
	Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр	82.7	6	85.9	80.1	86.2	74.5	86.4	93.3

10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ
		... %

ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА.

Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.32 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 12 дугаар тогтоолоор “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталсан.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2020 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтантай ярилцах, холбогдох газраас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Хөтөлбөрийн зорилго. **Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.**

Хөтөлбөрийн зорилт.

Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;
Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;
Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;
Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.
Хүлээгдэж буй үр дүн
Зорилт 1. Нийт 92 журам, заавар батлуулсан байна.
Зорилт 2. Халдварт өвчингүй статустай газар нутгийн хэмжээг 10 хувьд хүргэх.
Зорилт 3. Гоц халдварт өвчний дархлаажуулалт хийж байгаа аймгийн тоо шүлхий -3, бог малын мялзан -0, хонь, ямааны цэцэг-0 болгох.
Зорилт 4. Мал эмнэлгийн хяналтын цэгээр дамжин өнгөрсөн мал, тээврийн хэрэгслийн тоо буурах.
Зорилт 5.Сургалтад хамрагдсан малын эмч, мэргэжилтний тоо 2700-д хүргэх.
Зорилт 6. Сургалтад хамруулсан малчин, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тоог 35000-д хүргэх.
Хэрэгжих хугацаа. **Хөтөлбөр нь 2018-2021 онд буюу 4 жилийн хугацаанд хэрэгжинэ.**
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ. Хөтөлбөрийн төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн үнэлгээ 83.8, үндэсний хөтөлбөрийн явцын хэрэгжилт 82.7 хувьтай байна. (График 1, Хүснэгт 1)

График 1



Малын эрүүл мэнд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, 2018-2021 он, зорилт тус бүрээр

Хүснэгт 1

Зорилт	2018 он	2019 он	2020 он	2021 он	Дундаж үнэлгээ
Зорилт 1	81.7	78.6	97.5	-	85.9
Зорилт 2	63.3	90.6	88.3	78.3	80.1
Зорилт 3	70.0	88.8	94.5	91.3	86.2
Зорилт 4	-	65.6	77.8	80.0	74.5
Зорилт 5	-	83.9	87.5	87.9	86.4
Зорилт 6	-	100	98.6	81.4	93.3
Дүн	71.7	84.6	90.7	83.8	82.7

Малын эрүүл мэнд хөтөлбөрийн төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн үнэлгээ, арга хэмжээний тоогоор (График 2)



Хүлээгдэж буй үр дүнгийн үзүүлэлт

Зорилт №	Хүлээгдэж буй үр дүн	Хүрсэн түвшин	Үнэлгээ
I	Нийт 92 журам, заавар батлуулсан байна.	104	100.0
II	Халдварт өвчингүй статустай газар нутгийн хэмжээг 10 хувьд хүргэх.	Гоц халдварт өвчингүй газар нутаг - 0, бусад халдварт өвчингүй газар нутаг - 2021 оны халдварт өвчний гаралтыг 2020 онтой харьцуулахад гаралт 849 буюу 27.1%	50.0
III	Гоц халдварт өвчний дархлаажуулалт хийж байгаа аймгийн тоо шүлхий -3, бог малын мялзан -0, хонь, ямааны цэцэг-0 болгох.	Шүлхий 21, бог малын мялзан 4, хонь, ямааны цэцэг 3	-
IV	Мал эмнэлгийн хяналтын цэгээр дамжин өнгөрсөн мал, тээврийн хэрэгслийн тоо буурах.	Тээврийн хэрэгсэл - 45719, мал, амьтан - 49614	90.0
V	Сургалтад хамрагдсан малын эмч, мэргэжилтний тоо 2700-д хүргэх.	11,040	100.0
VI	Сургалтад хамруулсан малчин, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тоог 35000-д хүргэх.	538,564	100.0
Дундаж үнэлгээ			73.3

Үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээ 73.3% буюу тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээгээр үнэлэгдлээ.

ДҮГНЭЛТ

1. Хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээ 83.8, хөтөлбөрийн явцын хэрэгжилт 82.7 хувиар тус тус үнэлэгдэж, тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээтэйгээр хөтөлбөр хэрэгжиж дууссан байна.
2. Салбарын хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн арга хэмжээг Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгасан нь тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээ авах гол нөхцөл болжээ.
3. Үндэсний хөтөлбөрийн зорилтуудаас үйл ажиллагааны зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ харьцангуй өндөр байгаа бол тусгайлсан төсөв бүххий зорилт арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ бага байна. Үүнд: Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох зорилтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ хамгийн бага /74.5%/ байна.

ЗӨВЛӨМЖ.

1. Үндэсний хөтөлбөр батлахаар бол хэрэгжүүлэх нэн шаардлагатай арга хэмжээг тусгайлсан төсөв хөрөнгөтэйгээр баталж, хэрэгжилтийг хангах чиглэлд бодлого төлөвлөгчид,
2. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох чиглэлийн арга хэмжээг үр дүнтэйгээр төлөвлөх, хэрэгжүүлэх чиглэлд хэрэгжүүлэгч байгууллага анхаарах шаардлагатай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2021 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1	3.1.1. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт өвчинтэй тэмцэх төлөвлөгөө (2018-2022)-г шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;	3.1.1.1. Шүлхий өвчинтэй тэмцэх төлөвлөгөө боловсруулж батлуулах;	2019		Төлөвлөгөө батлагдсан байна.	Шүлхий өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.	100.0
2		3.1.1.2. Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг боловсруулж, батлуулах;	2019		Заавар батлагдсан байна	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/58 дугаар тушаалын хавсралтаар "Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар"-ыг баталж, хууль эрх зүйн мэдээллийн санд бүртгүүлсэн. https://www.legalinfo.mn/law/details/13966	100.0
3		3.1.1.3. Бог малын мялзан өвчинтэй тэмцэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах;	2019		Төлөвлөгөө батлагдсан байна.	Бог малын мялзан өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн төслийг 2016 онд төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн шинэчилж, ХХААХҮ-ийн сайдаар батлуулахад бэлэн болгосон. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг баталсан. https://www.legalinfo.mn/annex/?lawid=14189	70.0
4		3.1.1.4. Бруцеллёз өвчинтэй тэмцэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах;	2019		Төлөвлөгөө батлагдсан байна.	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-154 дүгээр тушаалаар баталсан "Малын бруцеллёзтой тэмцэх стратеги, төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөний төслийг бэлтгэхээр ажиллаж байна.	50.0
5		3.1.1.5. Дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	2019		Төлөвлөгөө батлагдсан байна.	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөний төслийг Мал эмнэлгийн Мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар батлуулан, мөрдөж байна.	100.0
6		3.1.1.6. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын улсын төлөвлөгөөг боловсруулж батлуулах;	2019		Төлөвлөгөө батлагдсан байна.	Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын улсын төлөвлөгөө” (ББТ)-г Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/190 дугаартай тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна.	100.0
7		3.1.1.7. Зооноз өвчнийг хяналтад авах хяналтад авах стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах;	2019		Төлөвлөгөө батлагдсан байна.	"Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөлийн ажиллах журам"-ыг ЭМ-ийн болон ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-449, А/544 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Зооноз өвчнийг хяналтад авах стратеги, төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.	50.0
8	3.1.2. Мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораториудыг сүлжээгээр ажиллах журам,	3.1.2.1. Улсын мал эмнэлгийн лаборатори болон Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид эцсийн оношогтоох мал, амьтны халдварт өвчний жагсаалтыг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Жагсаалт батлагдсан байна.	Улс, аймаг, нийслэл, сум дүүргийн түвшинд мал эмнэлгийн лабораторийн шинжилгээ хийх аргын жагсаалтыг боловсруулан холбогдох байгууллага, мэргэжилтнүүдээс саналыг тусган, МЭЕГ-ын даргын 2021 оны А/55 дугаар тушаалаар батлуулан УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн МЭГ-т цахимаар хүргүүлсэн.	100.0

9	бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг шинээр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;	3.1.2.2. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журмыг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Журам батлагдсан байна.	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журмын төсөлд холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн саналыг тусган, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-303 дугаар тушаалаар батлуулан эрхзүйн мэдээлэлийн нэгдсэн системд бүртгүүлсэн. https://www.legalinfo.mn/law/details/15637?lawid=15637	100.0
10		3.1.2.3. Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Журам батлагдсан байна.	Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмын төсөлд холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн саналыг тусган, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-324 дүгээр тушаалаар батлуулан эрхзүйн мэдээлэлийн нэгдсэн системд бүртгүүлсэн. https://www.legalinfo.mn/law/details/15654?lawid=15654	100.0
11		3.1.2.4. Мал эмнэлгийн лабораторийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Стратеги батлагдсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны "Мал эмнэлгийн лабораторийн үндэсний сүлжээг хөгжүүлэх богино болон дунд хугацааны стратеги батлах тухай" А/310 дугаар тушаалаар 2021-2030 онд мал эмнэлгийн лабораторийн үндэсний сүлжээг хөгжүүлэх богино болон дунд хугацааны стратегийг батлан хэрэгжүүлж байна.	100.0
12	3.1.3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт болон паразиттах өвчинтэй тэмцэх зааврыг шинэчлэн өвчний тохиолдол, оношилгоо, хариу арга хэмжээнд баримтлах зааврыг өвчин тус бүрээр боловсруулж батлуулан мөрдүүлэх;	3.1.3.1. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019		Зааврууд батлагдсан байна.	Мал, амьтны гоц халдварт шүлхий, хонины цэцэг, шувууны томуу, боом, галзуу гэх мэт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын 14 төслийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/187 дугаар тушаалаар батлуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд байршуулсан.	100.0
13		3.1.3.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны халдварт цусан халдвар, дотрын халдварт хордлого гэх мэт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын 43 төслийг МЭЕГ-ын даргын 2019 оны А/14 дүгээр тушаалаар батлуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд байршуулсан.	100.0
14		3.1.3.3. Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны сүрьеэ, бруцеллёз, галзуу, боом гэх мэт зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврууудын төслийг МЭЕГ-ын даргын 2019 оны А/03 дугаар тушаалаар батлуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд байршуулсан.	100.0
15		3.1.3.4. Шимэгчтэх өвчинтэй тэмцэх стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	2018 - 2019			Мал, амьтны шимэгчтэх эргүү, бэтэг, бабезиоз гэх мэт шимэгчтэх өвчнөөс сэргийлэх, тэмцэх зааврын 14 төслийг МЭЕГ-ын даргын 2018 оны А/64 дүгээр тушалаар батлуулж, хууль эрх зүйн мэдээллийн санд байршуулсан	100.0
16	3.1.4. Малын шилжилт хөдөлгөөн, мал аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнд тавигдах дотоодын стандарт, чанар, аюулгүй байдлын	3.1.4.1. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл;	2018 - 2019		Журам батлагдсан байна.	Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”, “Отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”, “Мах бэлтгэлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”-ийг тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100.0
17		3.1.4.2. Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл	2018 - 2019			Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор "Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт", "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам" батлуулсан.	100.0

	шаардлага, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;	ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;				https://www.legalinfo.mn/law/details/13648	
18		3.1.4.3. Мал амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			МЭЕГ-ын даргын 2018 оны А/30 дугаартай тушаалаар журмыг батлуулан Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлсэн. https://legalinfo.mn/mn/detail/14077	100.0
19		3.1.4.4. Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавриг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			"Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар"-ыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан 4156 дугаарт бүртгүүлж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 95 дугаар тоот албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасгийн эмч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт танилцуулав.	100.0
20		3.1.4.5. Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			"Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам"-ыг ХХАА ХҮ-ийн сайдын 2019 оны А/08 дугаар тушаалаар, “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”, ”Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн загвар”, “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн (код) индексийн дугаар”-ыг ХХАА ХҮ-ийн сайдын 2019 оны А/234 дүгээр тушаалаар тус тус батлуулж Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлсэн. “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”-ын дагуу сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 987 гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид баталгааны тэмдэг олгосон. Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журмыг хэрэгжүүлэх зорилгоор МЭЕГ-ын даргын тушаалаар мал төхөөрөх 68 үйлдвэрт мал эмнэлгийн улсын байцаагч томилон журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн журмын хэрэгжилтийг хангах зорилгоор МЭЕГ-ын тушаалаар "Хүнсний зориулалтаар мал бэлтгэх, тээвэрлэх, тууварлах, үйлдвэрт хүлээн авах, төхөөрөх үед мал эмнэлэг-ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийх, үнэлэх стандарт ажиллагааны түр заавар" батлуулан Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх ажил хийгдэж байна.	100.0
21		3.1.4.6. Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019		Мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага хангагдсан байна.	"Хот суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэхэд тавигдах мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага"-ыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын бүртгүүлэн, мөрдөж байна.	100.0
22		3.1.4.7. Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмыг боловсруулан батлуулах;	2018 - 2019		Журам батлагдсан байна.	МЭЕГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж журам, жагсаалтын төслийг боловсруулж, хэлэлцүүлэг хийж, эцэслэхэд бэлтгээд байна.	50.0
23		3.1.4.8. Түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ	2018 - 2019		Заавар батлагдсан байна.	“Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар батлуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан 4156 дугаарт бүртгүүлж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 95 тоот албан бичгээр Мэргэжлийн хяналтын	100.0

		олгох зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;				ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрарт хүргүүлж 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасгийн эмч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт танилцуулав.	
24		3.1.4.9. Магадлан шинжилгээний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			“Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/46 дугаар тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар болон 332 сум, 6 дүүргийн мал эмнэлгийн тасгийн эмч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт танилцуулав.	100.0
25		3.1.4.10. Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх ариун цэвэр, эрүүл ахуйн зааврыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2019			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар "Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх эрүүл ахуй, ариун цэврийн заавар"-ыг нэгдүгээр, Хот суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэхэд тавигдах мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага"-ыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын 4207 дугаарт бүртгүүлж хэрэгжилтийг зохион байгуулж байна.	100.0
26	3.1.5. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд мөрдөх журам, стандартуудыг боловсруулж мөрдүүлэх.	3.1.5.1. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020		Журам батлагдсан байна.	"Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ын төслийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/457 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 4560 дугаарт бүртгүүлж хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.	100.0
27		3.1.5.2. Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020			Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмын төслийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-375 дугаар тушаалаар батлуулан, мөрдөж байна.	100.0
28		3.1.5.3. Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020			"Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам"-ын төслийг ХХААХҮ-ийн сайдын А-323 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний улсын бүртгэлд бүртгүүлэн, үйл ажиллагаандаа мөрдөж байна.	100.0
29		3.1.5.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулан батлуулах;	2018 - 2020		Норматив батлагдсан байна.	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативын төслийг Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2021 оны 118, А-201 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.	100.0
3.1 дүгээр зорилт							**85.9**
30	3.2.1. Мал эмнэлгийн салбарын мэдээллийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох;	3.2.1.1. Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчний мэдээллийн сан бий болгон ажиллуулах;	2019		Цахим бүртгэлийн сантай болсон байна.	Мал эмнэлгийн ерөнхий газар, Швейцарын элчин сайдын яамны хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээний хүрээнд Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/167 дугаартай тушаал болон малын эрүүл мэндийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг 21 аймаг, нийслэлд зохион байгуулсан. Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлснээр аймаг, нийслэлийн мал эмнэлгүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт хийх, халдварт, гоц халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчний дуудлага болон өвчлөлийг бүртгэн, Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчний мэдээллийн санг бий болгосон.	100.0

31		3.2.1.2. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг мөшгөн тогтоох нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгон ажиллуулах;	2019			ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШХА-ийн Ногоон алт- малын эрүүл мэнд төсөл, “Дижитал медик” ХХК-тай хамтран Мал эмнэлгийн гэрчилгээжүүлэлт, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн цахим системийг 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн мал эмнэлгийн газар, тасаг, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт мал эмнэлгийн гэрчилгээний системийг шинээр суулгах, хэрэглэгчийн нууц үгийг сэргээх, бааз дахь мэдээг ашиглах, цахим гэрчилгээ бичих, төлөвлөгөө оруулах, дуудлага үйлчилгээ хийх үзүүлэх сургалт зохион байгуулж, мал эмнэлгийн цахим системийг нэвтрүүлж нийт 2173 малын эмч хамруулав.	100.0
32		3.2.1.3. Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх тандалтын нэгдсэн цахим бүртгэлийг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлэх ;	2019 - 2020			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын Швейцарын элчин сайдын яамны хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээ, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/167 дугаар тушаал болон малын эрүүл мэндийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажил зохион байгуулах нэгдсэн удирдамжийн дагуу 21 аймаг нийслэлийн мал эмнэлгийн газар, сумын тасгийн мэргэжилтэн, нэгжийн эмч нар, мал аж ахуй эрхлэгчид нартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 06-с 2019 оны 12 сарын 20-ны дотор сургалт зохион байгуулж нэвтрүүлсэн. Систем нэвтрүүлэлтийн ажлыг МЭЕГ, МонҮМЭХ, нийслэл, аймгийн МЭГ, Ногоон алт малын эрүүл мэнд төсөл, Дижитал медик ХХК-ийн хамтарсан баг гүйцэтгэсэн. Сумын малын шилжилт хөдөлгөөнийг хянах, эргэн мөшгөх тогтолцоог бий болгох, мал амьтны өвчнийг тандах, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөхөд хэрэглэгдэх, Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх тандалтын нэгдсэн цахим бүртгэлийг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлснээр мал эмнэлгийн нэгдсэн системд мэдээллийн санг бий болгосон. Улсын хэмжээнд мал эмнэлгийн нэгдсэн системд нийт 2173 малын эмч хамруулав.	100.0
33	3.2.2. Бүсийн оношилгоо, шинжилгээний лабораторийг зүүн, хангайн, баруун бүсэд өргөтгөн байгуулж, дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх;	3.2.2.1. Баруун бүсэд мал эмнэлгийн лабораториийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах	2020 - 2021		3 бүсэд бүсийн лаборатори байгуулагдсан байна.	Ховд аймгийн мал эмнэлгийн лабораторийг Бүсийн лабораторийн статустайгаар ажиллах нөхцөл хангахын тулд 274.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мал эмнэлгийн лабораторийн барилгын их засварын ажлын төсөв” боловсруулж, их засварын ажлын зураг төсөл батлуулсан. Санхүүжүүлэх саналыг НҮБ-ын ХХААБ-ын “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төсөлд хүргүүлсэн. Лабораторийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, уг төслийг санхүүжүүлэх боломжтой гэж дүгнэсэн. Мал эмнэлгийн лабораторийн оношлогооны хүчин чадлыг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай байгаа 23 нэр төрлийн 45 ширхэг /иж бүрэн/ лабораторийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, оношлуур урвалжийг жагсаалтаар гаргаж дээрх төслөөс санхүүжилт авах саналыг хүргүүллээ.	50.0
34		3.2.2.2. Хангайн бүсэд мал эмнэлгийн лабораториийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах;	2020 - 2021			Төвийн бүсэд мал эмнэлгийн лабораториийг өргөтгөн бүсийн лабораторийг Булган аймагт байгуулах ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.	50.0
35		3.2.2.3. Зүүн бүсэд мал эмнэлгийн лабораториийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах;	2020 - 2021			Зүүн бүсэд мал эмнэлгийн лабораториийг өргөтгөн бүсийн лабораторийг Хэнтий аймагт байгуулах ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.	50.0
36	3.2.3. Төв, орон нутгийн мал	3.2.3.1. Мал эмнэлгийн лабораторийн барилгыг шинээр	2019 - 2021		Лабораторийн тоног	Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр Дорноговь, Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн лабораторийн барилгын ажлууд Ковидийн үеийн хил гаалийн	100.0

	эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораторийн барилга, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх, лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуур, тоног төхөөрөмжийн	болон шинэчлэн барих, тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээг хийх арга хэмжээг зохион байгуулах;			төхөөрөмжийн хэвийн ажиллах үйл ажиллагааг хангасан байна.	хязгаарлалттай холбоотойгоор түр зогссон. Дорноговь аймгийн гражийн барилга 100, шатаах зуухын барилгын явц 100, лабораторийн барилгын явц 90%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн газар баригдаж буй лабораторийн иж бүрэн барилгын гражийн барилга 65, шатаах зуухны барилга 65, лабораторийн барилгын гүйцэтгэл 75%-тай байна. Архангай аймгийн орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар мал эмнэлгийн лабораторийн барилгын ажлыг 1 тэрбум төгрөгөөр 2021 оны 1 сард ашиглалтад хүлээн авсан. Өмнөговь аймаг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн хүнсний лабораторийн барилгын ажлыг улсын төсвөөр 484.4, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 594.3 сая, нийт 987.432.888 төгрөгөөр гүйцэтгэж 2019 оны 12 дугаар сард хүлээлгэж өгсөн байна.	
37	нөхөн хангалт хийх, зохих нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах;	3.2.3.2. Мал эмнэлгийн лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуурын хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;	2019 - 2021	906.6 сая	Өвчнийг эрт илрүүлэх нөхцөлөөр хангагдана.	2019 онд лабораториудад шаардлагатай эм урвалж, оношлуур, тоног төхөөрөмж худалдан авах МЭТШ/2019/5 тендерт хил залгаа ОХУ, БНХАУ-д гараад байгаа гахайн африкийн мялзан, үхрийн арьсны товруутах үрэвсэл зэрэг шинэ болон дахин сэргэж болзошгүй өвчний оношлуур худалдан авч лабораторийн оношилгооны бэлэн байдлыг хангасан. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр төв болон баруун бүсийн аймгуудад шүлхий оношлуур, хэрэглэгдэхүүн нийлүүлсэн. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, эм урвалж, шил сав худалдан авах МЭТШ2021/04-02 дугаартай тендерийг 2021 онд 3 багцтайгаар шалгаруулан, нийт 906,610,765 төгрөгийн оношлуур, эм урвалжийн худалдан авалт хийсэн.	100.0
38		3.2.3.3. Гоц халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнийг оношлох оношлуурын нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлж, ашиглалтыг сайжруулах;	2019 - 2021	349.5 сая		Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2019 онд Гоц халдварт шүлхий өвчний оношлуур, урвалж худалдан авах МЭТШ/2019/02, Мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, эм урвалж, шил сав худалдан авах МЭТШ/2019/05-1, МЭТШ/2019/05-2, МЭТШ/2019/05-3, Гоц халдварт бог малын мялзан өвчний оношлуур, хэрэглэгдэхүүн худалдан авах МЭТШ/2019/04 Г-2019/04, Бруцеллёз өвчнийг эрүүлжүүлэх шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл худалдан авах МЭТШ/2019/03 дугаартай тендер тус тус зарлаж, УМЭАЦТЛ, МЭХ, Аймаг нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад хуваарийн дагуу хүргүүлсэн. 2021 онд гоц халдварт шүлхий өвчний оношлуур, урвалж худалдан авах МЭТШ/2021/04-05, БММӨ-ий оношлуур, худалдан авах МЭТШ/2021/04-06 тендер шалгаруулж, нийт 349,542,800 төгрөгийн оношлуур нийлүүлсэн.	100.0
39	3.2.4. Шинжлэх ухааны тооцоо, судалгаанд тулгуурласан тандалт судалгааг хийх загварыг сум, аймаг, бүсийн түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг нэгтгэх, тандалт,	3.2.4.1. Тархвар зүйн судалгааны хуудасны загвар, судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулах;	2019 - 2020		Төлөвлөгөө батлагдсан байна.	Тархварзүйн судалгаа хийх төлөвлөгөө, судалгааны загвар хуудсыг МЭЕГ-ын даргын 2019 оны А/187 дугаар тушаалаар батлуулсан.	100.0
40		3.2.4.2. Баруун бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020	78.0 сая /төсөл/	6 аймагт халдварт өвчнийг тандах загвар боловсрогдон, үр дүнг тооцсон байна.	Баруун бүсийн 5 аймагт НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран бог малын мялзан өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалт, шинжилгээний загвар гарган сорьц бэлтгэх ажил хийгдэж байна. НҮБ-ын ХХААБ болон МЭЕГ хоорондын “Монгол улсын төвийн болон баруун бүсэд бог малын мялзан өвчний тандалт судалгааг хэрэгжүүлэх” ажлын гэрээг 2019 оны 12 сарын 18-ны өдөр баталж тандалтын ажлыг 2020 оны 2 дугаар сараас гүйцэтгэсэн. Бог малын мялзан өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалт, шинжилгээг баруун бүсийн 5 аймаг (Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан)-т сонгосон өрхийн нийт 4000 мэдрэмтгий малаас цусны дээж цуглуулж хийсэн. Шинжилгээний дүнгээр Баян-	100

	шинжилгээний ажлын эдийн засгийн үр ашгийг тооцох;					Өлгий аймгийн 4 сумын 800 дээжээс 107 эерэг буюу 13,3%-д, Ховд аймгийн 4 сумын нийт 800 дээжээс 31 эерэг буюу 3,8%-д, Увс аймгийн 4 сумын 800 дээжээс 33 эерэг буюу 4,1%-д, Завхан аймгийн 4 сумын 800 дээжээс 19 эерэг буюу 2.3%-д нь тус тус эсрэгбием илрэв. Шүлхий өвчнөөс баруун бүсийн 6 аймаг эрүүлийг баталгаажуулах ийлдсийн тандалтын ажлын хүрээнд Ковид-19 өвчний нөхцөл байдалтай уялдуулан МЭТ, МЭҮН-ийн эмч сорьц бэлтгэж, аймгийн МЭЛ шинжилгээг гүйцэтгэн үр дүнг УМЭАЦТЛ нэгтгэж, МЭЕГ-т хүргүүлэх загварыг бэлтгэн 2021 оны 5-6-р сард амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд цаашид энэ загварын дагуу тандалт, шинжилгээний ажлыг гүйцэтгэхээр төлөвлөөд байна. Малын бруцеллёзтой тэмцэх стратегийн хүрээнд бүсчилсэн тандалт хийх аргачлалын хүрээнд дээж авах, сорьц тээвэрлэх, мониторинг хийх аргачлал, САЗ-ын хүрээнд жил бүр тандалт хийж хэвшсэн. Дэлхийн банкны МААЭЗЭН төслийн дэмжлэгтэйгээр цаашид аливаа сорьцыг авахдаа олон удаагийн шинжилгээ хийхээр авах, 1 сорьцод хэд хэдэн тандалт хийх, махны үйлдвэрийг түшиглэн зардал, хугацаа хэмнэсэн тандалт хийх аргачлалыг нэвтрүүлээд байна.	
41		3.2.4.3. Хангайн бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			НҮБ-ын ХХААБ-ын зөвлөх үйлчилгээний хүрээнд 2019 оны 3 улиралд загвар боловсруулж, 9-р сард тандалтыг хийсэн. “Монгол улсын төвийн болон баруун бүсэд бог малын мялзан өвчний тандалт судалгааг хэрэгжүүлэх” ажлын гэрээг 2019 оны 12 сарын 18-ны өдөр баталж, тандалтын ажлыг 2020 оны 2 дугаар сараас гүйцэтгэсэн. Улсын захиалгат тандалтаар Төвийн бүсийн 5 аймаг буюу Төв, Дундговь, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотыг сонгон 18 сум, 4 дүүрэг, 44 багийн 220 малчин өрхөөс нийт 3080 хонь, ямааны цусны ийлдэсний дээж цуглуулан БММӨ-ий халдвар илрүүлэх ийлдсийн тандалт явуулав. Лабораторийн шинжилгээгээр Сэлэнгэ 700, Дундговь 700, Дархан-Уул 420, Улаанбаатар 560 сорьц арга зүйн дагуу цуглуулж, бог малын 2380 ийлдсийг эсрэгбием илрүүлэх цомгоор шинжлэхэд эерэг болон сэжигтэй дээж илрээгүй. Төв аймгийн 5 сумын 700 дээжнээс 20 эерэг буюу 2.8% (нийт дээжийн 0.8%)-д нь эсрэгбием илрэв. Баталгаажуулах шинжилгээнд эсрэгбием илэрсэн, хот айлын малаас санамсаргүй сонголтоор ийлдсийн 96, арчдасын 56 дээж авч, ЭЛИЗА урвал, молекул биологийн шинжилгээг хийхэд бүх дээжид БММ өвчний эсрэгбием болон вирусийн генийн хэсэг илрээгүй. Шүлхий, бог малын мялзан өвчний халдварын хүрээг тогтоох ийлдсийн тандалт шинжилгээнд зориулан нэг сорьц бэлтгэж шинжилгээг гүйцэтгэх загварын дагуу 2020-2021 оны тандалт шинжилгээг гүйцэтгэсэн. Шинжилгээнд зориулан бэлтгэж байгаа сорьц авах малын насыг сайтар харгалзан сорьц бэлтгэх шаардлагатай болохыг дүгнэлтэд хүрээд байна. Малын бруцеллёзтой тэмцэх стратегийн хүрээнд бүсчилсэн тандалт хийх аргачлалын хүрээнд дээж авах, сорьц тээвэрлэх, мониторинг хийх аргачлал, САЗ-ын хүрээнд жил бүр тандалт хийж хэвшсэн. Дэлхийн банкны МААЭЗЭН төслийн дэмжлэгтэйгээр цаашид аливаа сорьц авахдаа олон удаагийн шинжилгээ хийхээр тооцох, 1 сорьцод хэд хэдэн тандалт хийх, махны үйлдвэрийг түшиглэн зардал, хугацаа хэмнэсэн тандалт хийх аргачлалыг нэвтрүүлээд байна.	100

42		3.2.4.4. Зүүн бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			НҮБ-ын ХХААБ-ын зөвлөх үйлчилгээний хүрээнд 2019 оны 3 улиралд загвар боловсруулан, тандалт хийсэн. 2021 онд зүүн бүсийн 5 аймагт шүлхий, бог малын мялзан өвчний сүргийн халдварлалтын түвшин тогтоох тандалт шинжилгээний хүрээнд Ковид-19 өвчний нөхцөл байдалтай уялдуулан МЭТ, МЭҮН-ийн эмч сорьц бэлтгэж, аймгийн МЭЛ шинжилгээг гүйцэтгэн үр дүнг УМЭАЦТЛ нэгтгэж, МЭЕГ-т хүргүүлэх загварыг бэлтгэн 2021 оны 5-6-р сард амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд цаашид энэ загварын дагуу тандалт, шинжилгээний ажлыг гүйцэтгэхээр төлөвлөөд байна. Малын бруцеллёзтой тэмцэх стратегийн хүрээнд бүсчилсэн тандалт хийх аргачлалын хүрээнд дээж авах, сорьц тээвэрлэх, мониторинг хийх аргачлал, САЗ-ын хүрээнд жил бүр тандалт хийж хэвшсэн. Дэлхийн банкны МААЭЗЭН төслийн дэмжлэгтэйгээр цаашид аливаа сорьц авахдаа олон удаагийн шинжилгээ хийхээр авах, 1 сорьцод хэд хэдэн тандалт хийх, махны үйлдвэрийг түшиглэн зардал, хугацаа хэмнэсэн тандалт хийх аргачлалыг нэвтрүүлээд байна.	100.0
43	3.2.5. Сум, аймаг, бүсийн түвшинд олон улсын худалдаанд саад тотгор учруулдаг, хүнсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа зарим өвчин (бруцеллез, сүрьеэ, шүлхий, бог малын мялзан)-өөс эрүүлжсэн болох талаар олон улсын жишигт нийцүүлэн баталгаажуулан мэдээлэх;	3.2.5.1. Шүлхий өвчийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийг төвийн бүсийн 7000, баруун бүсийн 7000 малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021	155.0 сая	Шүлхий, мялзан өвчнөөр тайван бүс нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, өвчнөөр тайван статусыг хадгална.	2021 онд малын гоц халдварт шүлхий өвчний халдвар илрүүлэх тандалтад 21 аймаг, нийслэлийн нийт 12870 толгой хивэгч малыг хамруулахаар төлөвлөснөөс баруун, зүүн, төвийн бүсээс нийт 16096 сорьц цуглуулан шинжилсэн, тандалт шинжилгээний гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй байна.	70.0
44		3.2.5.2. Бог малын мялзан өвчнийг эрт илрүүлэх шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийг баруун болон зүүн бүсийн 5 аймгийн 10000 мянан малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах	2018 - 2021	95.0 сая		Бог малын мялзан өвчний халдвар илрүүлэх тандалтад баруун болон төвийн бүсийн 16 аймаг, нийслэлийн нийт 11160 толгой хивэгч малыг хамруулахаар төлөвлөснөөс төвийн бүсээс 9 аймаг, нийслэлийн 3602 ийлдсийн сорьц, баруун бүсээс 7 аймгийн 4465 ийлдэсийн сорьц цуглуулан тандалт шинжилгээг явуулсан, тандалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 72.2 хувийн биелэлттэй байна.	90.0
45		3.2.5.3. Үхрийн сүрьеэ өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021	83.2 сая	Үхрийн сүрьеэ, бруцеллёз өвчнөөс эрүүл болохыг тогтоосон байна.	Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийн "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз, адууны ям өвчингүй, тайван байдал"-ыг тогтоохдоо ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/40 дүгээр тушаалаар батлсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ын дагуу МЭЕГ-ын даргын 2019 оны А/76, А/155 дугаар тушаалаар шинжээчийн баг томилон эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, МЭЕГ-ын даргын 2019 оны А/256 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн үхэр сүргийг “Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс”, Дархан-Уул аймгийн үхэр сүргийг “Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван бүс”-ээр тус тус тогтоон зарласан. Улаанбаатар хотын 3.0 мянган үхэрт сүрьеэ өвчний тандалт хийж, үр дүнг нэгтгээд байна. Үхрийн сүрьеэ, лейкоз өвчний эрүүлийг баталгаажуулах тандалт шинжилгээнд 21 аймаг, нийслэлийн нийт 5136 үхэр хамруулж, тандалтын гүйцэтгэл 98.5% дүнтэй гарсан.	90.0

46		3.2.5.4. Бруцеллёз өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021	599.0 сая		2018 онд хээлтүүлэгч малын 17 аймаг, нийслэлийн малд хийсэн бруцеллёзын ийлдэс судлалын шинжилгээнд нийт 242350 сорьц шинжлэгдсэнээс илрүүлэх шинжилгээгээр 0.35% буюу 856 нь эерэг гарсан. Нэгээс бусад аймаг, нийслэлд халдвар илэрч сумын 46.5% (127/273), багийн 23.2% (249/1072), өрхийн 1.2% (679/54590)-д нь бруцеллёзын тархалттай байна. Шинжлэгдсэн нийт буурын 0.53% (11/279), бухын 0.55% (141/25453), хуцын 0.34% (396/117816), ухнын 0.31% (304/97030) -д нь тус тус эсрэг бием илэрсэн. Аймгийн дунджаар 0.02-1.7% халдварлалттай, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, УБ хотод бусад аймгаас өндөр халдварлалттай байсан бол Өмнөговь аймагт эерэг дээж илрээгүй. 2019 онд хээлтүүлэгч малын бруцеллёзын шинжилгээнд 321 сум дүүргийн 1236 багийн 50596 өрх айлаас 294.1 мянган дээж авч, төлөвлөгөөг 79.3%-тай хамрагдсан. Бруцеллёзын илрүүлэх шинжилгээгээр эерэг гарсан дүнг ХХУ-аар баталгаажуулсан үр дүнгээс үзэхэд 0.2% (593/294140) нь эерэг дүн үзүүлсэн. 2020 онд Малын халдварт бруцеллёз өвчний эрүүлийг баталгаажуулах тандалт шинжилгээнд 20 аймаг нийслэлийн нийт 283244 мал хамруулж, гүйцэтгэл 76.0%-тай хэрэгжсэн. 2021 онд 353.0 мянган толгой хээлтүүлэгч малыг шинжлэхээс 283.2 мянган малын сорьцыг шинжилсэн. Улсын хэмжээнд 702 сорьц эерэг буюу өвчтэй гарч, 0.25%-ийн халдварлалттай байна. 2018-2020 онд хийсэн шинжилгээний дүнгээр халдварлалтын хувь буурсан боловч 2021 онд 0.04%-иар өссөн байна	100.0
47		3.2.5.5. Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулах	2018 - 2021	70.0 сая	ДМАЭМБ-аас 2 өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулсан байна.	Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулах ажлыг 2018-2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/61 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. 2018 онд Увс, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгаас 580 үхрийн, 887 ямааны цусны ийлдсийн сорьц, уушгины үрэвслийн шинж тэмдэгтэй үхрийн 2 сорьцыг нян судлалын шинжилгээнд тус тус цуглуулж, тандалт хийсэн. 2019 онд МЭХ-тэй гэрээ байгуулан 3000-аас дээш үхэрт түүвэр байдлаар тандалт хийсэн. Нян судлал, молекул биологийн шинжилгээнд зориулж нийт 9 аймгийн Мал эмнэлгийн газраас үхрийн уушгины эмгэг өөрчлөлттэй сорьц 160, ямааны уушгины сорьц 230-ыг илгээсэн. Судалгааны багийн гишүүд 2019 онд үхрийн 100, ямааны 188 эмгэгт сорьц цуглуулав. Тандалт судалгааны ажилд үхрээс цуглуулсан 267, ямаанаас цуглуулсан 450 сорьцыг нян судлал болон молекул биологийн судалгаанд ашиглаж байна. Монгол улсыг үхрийн цээж өвчнөөс эрүүл болохыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулах ажлын хүрээнд 2021 оны 8 дугаар сард Франц улсын CIRAD-ын лавлагаа лабораторит эерэг гарсан 7 сорьцыг хүргүүлсэн бөгөөд үхрийн цээж өвчин биш гэсэн хариу ирүүлсэн байна. Мөн үхрийн цээж өвчний доссиертой холбоотойгоор ДМАЭМБ-аас асуумж, тодруулга ирүүлснийг 2021 оны 9 дүгээр сард хариу, нэмэлт тайлбарын хамт хүргүүлсэн.	70.0
48		3.2.5.6. Зарим гоц болон архаг халдварт өвчнийг сум, аймгийн түвшинд баталгаажуулан мэдээллэх;	2018 - 2021		Нийт нутаг дэвсгэрийн 10 хувийг зарим гоц халдварт, архаг халдварт	“Малын бруцеллёзтой тэмцэх стратеги, төлөвлөгөө“, МЭЕГ-ын даргын тушаалаар “Нийслэлийн үхрийн аж ахуйг бруцеллёз өвчнөөр тайван нэгж/суурийг тодорхойлж, баталгаажуулах, сүрьеэ өвчнийг тандах“ ажлын хүрээнд нийслэл орчмын аж ахуйн нэгж, малчин өрхийн үхэр сүрэгт бруцеллёз, сүрьеэ өвчний тандалт шинжилгээг хийж дээрх өвчнөөс эрүүл аж ахуйн нэгж, малчин өрхийг тодорхойлж сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах зорилтыг тавьж, Хан- Уул дүүргийн 390 өрхийн 4113 үнээ,	90.0

					өвчнөөр эрүүл болохыг баталгаажуулсан байна.	Сонгино хайрхан дүүргийн 706 өрхийн 8146 үнээ, Баянзүрх дүүргийн 615 өрхийн 4924 үнээ, Налайх дүүргийн 429 өрхийн 3447 үнээ, нийт 2140 малчин өрхийн 20630 үнээний сүүний 2140 дээж шинжилгээнд хамруулсан. Нийслэлийн хэмжээнд 34048 цусны дээжийг илрүүлэх урвалаар шинжлэхэд 514 дээж эерэг дүн үзүүлсэн. Эдгээр 514 дээжид IDVET FRANCE улсын бруцеллёз өвчний эсрэгбием илрүүлэх ЕЛИЗА урвалын цомгийг ашиглаж шинжилгээг хийхэд 283 дээжид бруцеллёзын эсрэг бием илэрсэн. Хавсран холбох урвалаар баталгаажуулах шинжилгээ хийхэд 131 өрхийн 248 дээжид бруцеллёзын эсрэгбием илэрсэн. Тус тайланг Мал эмнэлгийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бруцеллёзоос эрүүл сүрэгтэн гэрчилгээ олгож байна. Өмнөговь аймгийн мал сүргийг "Малын бруцеллёз өвчингүй, тайван байдал"-ыг, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн мал сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз, адууны ям өвчингүй, тайван байдал"-ыг тогтоолгох хүсэлтийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, ХХАААХҮ-ийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ын дагуу МЭЕГ-ын даргын 2019 оны А/76, А/155 дугаар тушаалаар шинжээчийн баг томилон эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн үнэлгээний тайланг Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулав. 2021 онд Монгол улсын хэмжээнд үхрийн сүрьеэ, лейкоз өвчнийг тандах зорилгоор нийт 21 аймаг, нийслэлийн 86 сумын, 170 багийн, 624 малчин өрхийн мэдрэмтгий насны үхрээс 5136 сорьц цуглуулах, шинжилгээ хийх гэрээг УМЭАЦТЛ-той байгуулан, санхүүжилтийн 80%-ийг шилжүүлснээр 2021 оны 10 дугаар сарын байдлаар 4824 сорьц цуглуулж, шинжилгээг хийхэд бэлэн болоод байна. Япон, Монгол улсын Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд Сатрепс төслөөр адууны ям, үхрийн сүрьеэ өвчний оношлуурыг сайжруулах зорилгоор МЭХ-тэй хамтран ажиллах гэрээг байгуулж, зүүн аймгуудаар сорьц цуглуулах ажлыг эхлүүлж, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймагт МЭХ-ийн ажлын хэсэг ажиллаж байна.	
49	3.3.1. Бүх шатны мал эмнэлгийн байгууллагуудад вакцин, эм бэлдмэлийг хадгалах хөргүүр, хүйтэн хэлхээгээр тээвэрлэх ложистик сүлжээг байгуулах;	3.3.1.1. Зүүн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад вакцин, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021		Вакцин, эм бэлдмэлийг хадгалах, хөргүүр, хүйтэн хэлхээгээр тээвэрлэх сүлжээг бүх шатанд бүрдүүлсэн байна.	Сүхбаатар, Дорнод аймгийн мал эмнэлгийн газрын вакцин хадгалах хөргүүрийн засвар үйлчилгээг хийлгэж хэвийн ажиллагаанд оруулсан. 2020 онд Биокомбинат УТҮГ-т вакцин тээвэрлэлтийн Foton машиныг МЭЕГ-аас тендерээр нийлүүлсэн. Дээрх машинаар вакцин тээврийн ажлыг саадгүй тээвэрлэж байна. Мөн зарим аймгуудын хөргүүрийг засварлах ажлыг гүйцэтгэсэн. 2021 онд аймаг, нийслэлийн	90.0
50		3.3.1.2. Хангайн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021			ХХАААХҮ-ийн Сайдын 2020 оны А-52 дугаар тушаалаар ХХАААХҮ-ийн салбарт 2020 онд төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалт санхүүжилтээр худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалтад "Орон нутагт малын вакцин тээвэрлэх автомашин" худалдан авахаар 160.0 сая төгрөгийн эх үүсвэр батлагдсан. МЭЕГ-ын даргын 2020 оны А-30 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороо байгуулж, Биокомбинат УТҮГ-т вакцин тээвэрлэлтийн Foton машиныг нийлүүлсэн. Мөн зарим аймгийн хөргүүрийг засварлах ажлыг гүйцэтгэсэн.	90.0
51		3.3.1.3. Төвийн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021			2020 онд Биокомбинат УТҮГ-т вакцин тээвэрлэлтийн Foton машиныг МЭЕГ-аас тендерээр нийлүүлсэн. Дээрх машинаар вакцин тээврийн ажлыг саадгүй тээвэрлэж байна. Мөн зарим аймгийн хөргүүрийг засварлах ажлыг гүйцэтгэсэн. 2021 онд аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газраас засвар хийх судалгаа авсан	90.0
52		3.3.1.4. Баруун бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм,	2020 - 2021			2020 онд Биокомбинат УТҮГ-т вакцин тээвэрлэлтийн Foton машиныг МЭЕГ-аас тендер зарлан нийлүүлсэн. Дээрх машинаар вакцин тээврийн ажлыг саадгүй	90.0

		биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах.				тээвэрлэж байна. Мөн зарим аймгийн хөргүүрийг засварлах ажлыг гүйцэтгэсэн. 2021 онд аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газраас засвар хийх судалгаа авсан	
53	3.3.2. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг тандан судалгааны үр дүнд үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх;	3.3.2.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021	262.6 сая	Вакцинд хамрагдалтыг 85 хувиас доошгүйд хүргэх, өвчнөөр тайван байдлаа хадгална.	Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс сэргийлэх 2021 оны яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЕГ-ын даргын 2021 оны А/51 дугаартай тушаалаар баталгаажуулсан. Бог малын мялзан өвчин гарсантай холбоотойгоор яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг тухай бүр нь шинэчлэн МЭЕГ-ын даргаар баталгаажуулж дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Бог малын мялзан өвчин 2021 оны 08-09-р сард Өмнөговь аймгийн 8 сум, Дундговь аймгийн 3 сум, Хэнтий аймгийн 2 сум, Нийслэлийн 1 дүүрэг, Ховд аймгийн 3 суманд оношлогдож урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Ховд аймагт зөөвөрлөгдөн очсон хээлтүүлэгч малд уг өвчин оношогдож 285 толгой хээлтүүлэгчийг устгалд хамруулж 10-р сарын 02-ны өдрөөс хойш дахин өвчний шинж тэмдэг илрээгүй байна. Өмнөговь, Дундговь, Хэнтий, Нийслэлийн нийт 1.9 сая толгой бог малыг МЭЕГ-ын нөөцөд хадгалагдаж байсан вакцинаар дархлаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэн, хорио цээрийн арга хэмжээг шуурхай хэрэгжүүлснээр тайван байна.	100.0
54		3.3.2.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021	15,985.2 сая	Вакцинд хамрагдалтыг 85 хувиас доошгүйд хүргэх, өвчнөөр тайван байдлаа хадгална.	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин 2021 он гарсаар 19 аймгийн 116 суманд 213 тохиолдол бүртгэгдэж, нийт 79860 толгой мал өвчилсөн. Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 12-р сарын 06-ны байдлаар нийт 11 аймгийн 56 сумын 104 голомтын хорио цээрийг бүрэн цуцалсан байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр нь хэрэгжүүлсэн бөгөөд дархлаажуулалтын арга хэмжээнд нийт 19 аймгийн 116 сумын 51,316 өрхийн тэмээ 21,659, үхэр 1,503,803, хонь 11,015,656, ямаа 10,559,241, гахай 17,410 толгой буюу улсын хэмжээнд нийт 23,169,085 толгой мэдрэмтгий мал хамруулсан. Дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн МЭҮН-д нийт 3.0 тэрбум төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон.	100.0
55		3.3.2.3. Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021	259.0 сая	Өвчнөөр тайван байдлаа хадгална	Мал, амьтны гоц халдварт хонины цэцэг өвчнөөс сэргийлэх 2021 оны төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЕГ-ын даргын 2021 оны А/48 дугаартай тушаалаар баталгаажуулсан. Хонины цэцгээс сэргийлэх 2021 оны дархлаажуулалтад шаардагдах нийт 3,0 сая тун вакциныг Биокомбинат УТҮГ-аас хүлээн авч 1,1 сая тун вакциныг 3 аймгийн 8 сумын нийт 1,1 сая толгой хонин сүргийг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр дархлаажуулалтад хамруулж, 1.5 сая тун вакциныг үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад ашиглан 462.0 мянган тун вакциныг нөөцөд хадгалж байна.	100.0
56		3.3.2.4. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах;	2019 - 2021	4,200.0 сая	Вакцинд хамрагдалтыг бодыг 60-аас, богийг 70-аас доошгүй хувьд хүргэж, өвчнөөр тайван	Бруцеллёзоос урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2021 онд 13.66 сая толгой охин төл хамруулж, 94.0%-тай гүйцэтгэсэн. Үйлчилгээний хөлсөнд 2.0 тэрбум төгрөг олгосон. Нийт 9 аймгийн 18 суманд хийсэн вакцины дараах мониторингийн дүнгээс үзэхэд 17 сумын дүн хангалттай сайн байсан бол Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 1 МЭҮН-ийн дүн 57.4% буюу хангалтгүй гэсэн дүн гарсан байна. Тус сумын МЭҮН-д арга хэмжээ тооцох, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг МЭЕГ-т ирүүлэх тухай уламжлаад байна.	100.0

					байдлаа хадгална		
57		3.3.2.5. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 18 нэрийн өвчний вакцинжуулалтыг голомт бүхий бүсүүдэд зохион байгуулах;	2019 - 2021	5,400.0 сая	Халдварт өвчний гаралт бүртгэгдсэн бүс, аймаг, сумын тоог бууруулсан байна.	Төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөгөөний төслийг Мал эмнэлгийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/48 дугаар тушаалаар баталсан. Уг төлөвлөгөөний дагуу 24.5 сая толгой мал, амьтныг 18 нэрийн вакцинд хамруулахаар төлөвлөж, эцсийн мэдээгээр 23.7 сая толгой мал, амьтныг хамруулж, 96.9%-тай гүйцэтгэсэн байна. 2021 оны халдварт өвчний гаралтыг 2020 онтой харьцуулахад гаралт 849 буюу 27.1%, өвчилсөн мал, амьтны тоо толгой 5935 буюу 33.8%, хорогдсон мал, амьтны тоо 2209 буюу 13.4%, устгалд орсон мал, амьтны тоо 229 буюу 41.9 %-аар тус тус буурсан байна.	100.0
58	3.3.3. Дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандан судалгаа, лабораторийн шинжилгээний аргаар үнэлэж хянах;	3.3.3.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар хийх;	2018 - 2021	75.0 сая	85%-аас доошгүй дархлаа тогтсоныг баталгаажуулна	Бог малын мялзан өвчний вакцины дархлаа шалгах тандалт шинжилгээг 2019 онд вакцин таригдсан зүүн бүсийн 5 аймгийн 34 сумын 65 багийн 355 өрхийн малаас нийт 7100 ийлдэсний дээж цуглуулж шинжлэхэд Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймагт дунджаар 66.3 хувийн дархлаа тогтсон байна. 2021 онд Бог малын мялзан өвчний дархлааны төвшнийг хянах, вакцинд хамрагдалтын хувийг нийт сүргийн дунд тогтоох зорилгоор Өмнөговь аймгийн 11, Дундговь аймгийн 3, Дорноговь аймгийн 1 сумаас нийт 940 бог малын ийлдэсний дээж цуглуулан шинжлэхэд 774 эерэг дүн үзүүлж дархлааны дундаж төвшин 82.0%-тай буюу дархлааны тогтоц сайн гарсан байна.	90.0
59		3.3.3.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	2018 - 2021	95.0 сая	85%-аас доошгүй дархлаа тогтсоныг баталгаажуулна	2020 онд Шүлхий өвчний вакцины дархлаа шалгах тандалт шинжилгээнд ОХУ-ын О, А хэвшлийн вакцин таригдсан 9 аймаг, нийслэлийн нийт сүргээс төлөөлөл болгон 4950 ийлдсийн дээж авч шинжилгээ хийсэн. Шүлхий өвчний вакцин тарьснаас хойш 21 дэх хоногт тогтсон дархлааг шалгахад О хэвшилд 84.8, А хэвшилд 85.7 хувийн эерэг үр дүнтэй байна. 2021 оны 9 сард ОХУ-ын тосон хүчлүүрт шүлхийн О, А хэвшлийн вакцин таригдсан мал сүрэгт вакцин таригдсанаас хойш 28 хоногийн дараах байдлаар дархлаа үүссэн байдлыг хянах, нийт сүргийн дунд вакцинд хамрагдалтын хувийг тогтоох зорилгоор Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Хэнтий, Ховд, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгаас нийт 630 дээж цуглуулж шинжлэхэд вакцины эсрэг үзүүлэх малын дархлааны хариу урвалын идэвх О хэвшилд 529 дээж эерэг буюу 80.3%, А хэвшилд 448 дээж эерэг буюу 68.3%-тай байна.	70.0
60		3.3.3.3. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	2018 - 2021	50.5 сая	85%-аас доошгүй дархлаа тогтсоныг баталгаажуулна	2018 онд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой “Бруцеллёзын вакцинжуулалтын дараах мониторинг хийх ажил гүйцэтгэх” МЭЕГ2018/АГ-04 дугаартай гэрээг 33.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан вакцинжуулалтын чанар, үр дүнг үнэлсэн. Увс, Завхан, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ аймгийн 16 сумын 960 тугал, 4160 хурга, 4160 ишиг, нийт 9228 цусны дээжид шинжилгээ хийсэн. Улсын хэмжээнд вакцины дархлааны идэвх 73.4%-тай гарсан ба Завхан аймгийн Тэлмэн, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын вакцинжуулалтын дүн хангалтгүй гарсан. 2019 онд УМЭАЦТЛ-той гэрээ байгуулан, гүйцэтгэсэн тандалтаар нийт 8 аймгийн, 16 сумын, 315 өрх, айлаас бүгд 9088 цусны дээж цуглуулан шинжилсэн. Вакцины дараах мониторингийн шинжилгээнд 4099 хурга, 4151 ишиг, 838 тугалын ийлдэсний дээжид шинжилгээ хийхэд 7775 дээж эерэг, 1313 дээж сөрөг гарч, сумдаар нь авч үзвэл 77.0-97.0%-ийн дархлаа тогтсон гэсэн дүн гарсан ба бруцеллёзын вакцинжуулалтын мониторингийн дүнгээр малын дархлааны хариу урвалын төвшин 85.5% байв. 2020 онд Зүүн, Баруун,	100.0

						Төвийн бүсийн 9 аймгийн 18 сумын нийт 8280 толгой төл малд бруцеллёзын вакцинжуулалтын мониторинг хийсэн дүнгээр 83.0%-тай байв. Энэ нь дархлаажуулалтын түвшин сайн байгааг харуулж байна. Хөвсгөл аймгийн вакцинжуулалтын дархлааны түвшин хамгийн өндөр буюу Мөрөн сум 96.0%, Түнэл сум 92.0%, Булган аймгийн Могод 92.0%-тай тус тус гарсан байна. Бруцеллёзоос урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын дараа 2021 онд 9 аймгийн 18 суманд хийсэн вакцины дараах мониторингийн дүнгээс үзэхэд 17 сумын дүн хангалттай сайн байсан бол Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 1 МЭҮН-ийн дүн 57.4% буюу хангалтгүй гарсан. Тус сумын МЭҮН-д арга хэмжээ тооцох, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг МЭЕГ-т ирүүлэх тухай уламжлаад байна.	
61	3.3.4. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд үндэслэн шаардлагатай вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;	3.3.4.1. Баруун бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021	773.9 сая	Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газруудад эм, бэлдмэл, вакцины нөөц бүрдүүлсэн байна.	МЭЕГ-ын даргын 2021 оны А/159 дүгээр тушаалаар томилсон ажлын хэсэг 2021 онд мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын хувцас, хэрэгсэл худалдан авах ажиллагаагаар 773,944,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийлүүлэгдэх барааг хүлээж авсан. МЭТШ/2021/04-02, 03, 04 дүгээр багцын хүрээнд баруун бүсэд малын гоц халдварт, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд үндэслэн шаардлагатай ариутгал, халдваргүйтгэлийн 2 нэрийн бодис (суперкилл 1000 кг, Хай-коф 1400 кг), 2 нэрийн халдвар хамгаалын хувцас (нэг удаагийн 2200 ширхэг, олон удаагийн 80 ширхэг) барааг тендерийн баримт бичиг, гэрээний шаардлагад нийцүүлэн хүлээн авч МЭЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж нөөц бүрдүүлсэн.	100.0
62		3.3.4.2. Хангайн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			МЭЕГ-ын даргын 2021 оны А/159 дүгээр тушаалаар томилсон ажлын хэсэг 2021 онд мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын хувцас, хэрэгсэл худалдан авах ажиллагаагаар 773,944,4 сая төгрөгний төсөвт өртөгтэй нийлүүлэгдэх барааг хүлээж авсан. МЭТШ/2021/04-02, 03, 04 дүгээр багцын хүрээнд баруун бүсэд малын гоц халдварт, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд үндэслэн шаардлагатай ариутгал, халдваргүйтгэлийн 2 нэрийн бодис (суперкилл 1000 кг, Хай-коф 1400 кг), 2 нэрийн халдвар хамгаалын хувцас нэг удаагийн 2200 ширхэг, олон удаагийн 80 ширхэг барааг тендерийн баримт бичиг, гэрээний шаардлагад нийцүүлэн хүлээн авч МЭЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж нөөц бүрдүүлсэн.	100.0
63		3.3.4.3. Төвийн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			МЭЕГ-ын даргын 2021 оны А/159 дүгээр тушаалаар томилсон ажлын хэсэг 2021 онд мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын хувцас, хэрэгсэл худалдан авах ажиллагаагаар 773,944,4 сая төгрөгний төсөвт өртөгтэй нийлүүлэгдэх барааг хүлээж авсан. МЭТШ/2021/04-02, 03, 04 дүгээр багцын хүрээнд баруун бүсэд малын гоц халдварт, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд үндэслэн шаардлагатай ариутгал, халдваргүйтгэлийн 2 нэрийн бодис (суперкилл 1000 кг, Хай-коф 1400 кг), 2 нэрийн халдвар хамгаалын хувцас нэг удаагийн 2200 ширхэг, олон удаагийн 80 ширхэг барааг тендерийн баримт бичиг, гэрээний шаардлагад нийцүүлэн хүлээн авч МЭЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж нөөц бүрдүүлсэн.	100.0
64		3.3.4.4. Зүүн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын	2019 - 2021			МЭЕГ-ын даргын 2021 оны А/159 дүгээр тушаалаар томилсон ажлын хэсэг 2021 онд мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалын хувцас, хэрэгсэл худалдан авах ажиллагаагаар 773,944,4 сая төгрөгний төсөвт өртөгтэй нийлүүлэгдэх барааг хүлээж авсан. МЭТШ/2021/04-02, 03, 04 дүгээр багцын хүрээнд баруун бүсэд малын гоц халдварт, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд	100.0

		багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;				үндэслэн шаардлагатай ариутгал, халдваргүйтгэлийн 2 нэрийн бодис (суперкилл 1000 кг, Хай-коф 1400 кг), 2 нэрийн халдвар хамгаллын хувцас нэг удаагийн 2200 ширхэг, олон удаагийн 80 ширхэг бараг тендерийн баримт бичиг, гэрээний шаардлагад нийцүүлэн хүлээн авч МЭЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж нөөц бүрдүүлсэн.	
65	3.3.5. Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины дотоодын үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлж, вакцины хэрэгцээг дотоодоос бүрэн хангах.	3.3.5.1. Вирусын гаралтай вакцины үйлдвэр байгуулах, үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх;	2019 - 2021		Вакцин үйлдвэрлэлийн технологиж бүрэн шинэчлэгдсэн байна.	Биокомбинат ТӨХХК-тай байгуулсан 2020 оны 12-р сарын 04-ний өдрийн МЭЕГ82020/048 дугаартай гэрээний дагуу шүлхийн вакциныг савлах туршилтын үйлдвэрлэлд шаардагдах вакцины өтгөрүүлэг, адъювант нийлүүлэгчийг сонгохоор tender.gov.mn цахим сайтаар дамжуулан 08-р сарын 18-ны өдөр нээлттэй тендер зарласан боловч оролцогч материал ирүүлээгүй тул 10-р сарын 06-ны өдөр 2 дахь удаа нээлттэй тендер зарласан. Тендерт нэгч оролцогч материал ирүүлээгүй тул МЭЕГ, МЭХ, Биокомбинат ТӨХХК-аас хамтарсан уулзалтыг зохион байгуулж гэрээг цуцлах шийдвэр гаргасан.	50.0
66		3.3.5.2. Биобэлдмэлийг орон нутагт хүргэх хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг сайжруулах;	2019 - 2021			Биокомбинат ТӨХХК нь улсын төсвөөр шинэчлэлт хийж 2020 онооc Foton маркийн 9 тн даацтай биобэлдмэл зөөвөрлөх зориулалтын хүйтэн хэлхээний машин авснаар орон нутагт биобэлдмэлийг зориулалтын дагуу тээвэрлэж хугацаандаа хүргэн ажиллаж байна.	100.0
67		3.3.5.3. Хэрэглээнд тулгуурлан вакцины сав, баглаа боодлыг шинэчлэн сайжруулах;	2019 - 2021			Биокомбинат ТӨХХК-ийн үйлдвэрлэдэг Гахайн сонгомол мялзангаас сэргийлэх вакцин нь жилдээ 1 цуврал үйлдвэрлэгддэг боловч хадгалалтын хугацаа богино, шингэлэгчийн савалгаа 200 мл-ээр савлагддаг нь үйлдвэрлэлд хэрэглэхэд хорогдол их гарах, гахайг бүрэн вакцинжуулах боломжгүй зэрэг асуудлууд гардаг. Иймд гахайн сонгомол мялзангаас сэргийлэх вакциныг жилд 2 цувралаар, шингэлэгчийг 100 мл-ээр савлаж байна. Мөн 2021 онд вакцины шошгонд өөрчлөлт хийж Бар кодтой болгосон.	100.0
68		3.3.5.4. Шинээр зохион бүтээгдсэн вакцин, оношлуурыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ;	2019 - 2021			Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээрийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр УИХ-аар хэлэлцэн баталж уг зээлийн гэрээний 2 жилээр сунгасан. Энэ хугацаанд “Сонгино дахь Биокомбинат УТҮГ-ын барилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх” тендерийг Монголын тал Унгарын холбогдох аж ахуйн нэгжүүдийн дунд нээлтэй тендер зарласан. Гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх вакциныг дотооддоо үйлдвэрлэх зорилгоор Цөмийн энергийн агентлагийн санхүүжилттэй вирусын вакцины үйлдвэрлэлийн цехийг 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр ашиглалтад оруулсан. Ингэснээр шүлхийн вакцины өтгөрүүлгийг дотооддоо шингэлэн савлаж, гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх болон нэн яаралтай нөхцөлд богино хугацаанд шуурхай арга хэмжээ авах боломж бүрдсэн. 2014 оноос хойш 4 нэрийн ийлдсийн үйлдвэрлэлийг зогсоож, ашиглахыг хориглосон байсныг 2020 оноос үйлдвэрлэх, хэрэглээнд нэвтрүүлэх шаардлага тавьсны хүрээнд колибактериоз, боом, цусан халдварын эмчилгээний ийлдсийг үйлдвэрлэж, хэрэглээнд нэвтрүүлээд байна.	70.0
69	3.4.2. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдсон чанар, эрүүл	3.4.2.1. Экспортын эрх авсан мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн байгууламж, технологийн үйл ажиллагааны горимыг импортлогч орон	2019 - 2021		Худалдаан ы олон талт хамтын ажиллагаа өргөжин	БНХАУ-аас ирүүлсэн саналын дагуу мах, махан бүтээгдэхүүн боловсруулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хянан магадалгааг улсын хэмжээнд ХХААХҮЯ, МЭЕГ, МХЕГ-ын хамтарсан ажлын хэсэг 69 мах төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт хийсэн. Хянан магадалгаагаар сайн дүгнэгдсэн 25 үйлдвэрийн нэрийг БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн ба 2019 оны 12 дугаарын 10-нд 4 хүний	70.0

	ахуй, хорио цээрийн гэрээ, хэлцэлийг гадаад улстай шинэчлэн байгуулах, өргөжүүлэх;	болон Евразийн эдийн засгийн гишүүн орнуудын мал эмнэлгийн дүрэм, журам, норм, норматив, шаардлагад нийцүүлэн баталгаажуулах;			хөгжсөн байна.	бүрэлдэхүүнтэй эрсдэлийн үнэлгээний баг ХХААХҮЯ, МЭЕГ, МХЕГ-тай хамтран нэр бүхий үйлдвэрүүдэд хянан магадалгааг хийсэн.	
70		3.4.2.2. Махны үйлдвэрүүдэд мөрдөх мал эмнэлэг, эрүүл ахуйн шаардлага, мах, махан бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг хянан баталгаажуулах зохистой дадлыг нэвтрүүлэх;	2019 - 2021		5 үйлдвэрт нэвтрүүлсэн байна.	Хүнсний мал бэлтгэх, тээвэрлэх, тууварлах, үйлдвэрт хүлээн авах, төхөөрөх үед мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийх, үнэлэх стандарт ажиллагааны түр зааврыг МЭЕГ-ын даргын 2019 оны А/154 дүгээр тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/196 дугаартай тушаалаар Хүнсний зориулалтаар мал төхөөрөлтөд бэлтгэх, тээвэрлэх, төхөөрөх үед мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийх, үнэлэх стандарт ажиллагааны зааврыг батлан аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн улсын /ахлах/ байцаагч нар үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр хөгжүүлэлт хийлгэсэн махны үйлдвэрийн үйл ажиллагааны системийг улсын хэмжээнд 2021 оны 7 дугаар сарын 01-ээс нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж 84 мал төхөөрөх үйлдвэр, нядалгааны газарт нэвтрүүлж, мал төхөөрөхийн өмнөх болон дараах мал эмнэлгийн үзлэг шинжилгээг толгой дараалан бүртгэж үйлдвэрүүдэд зохистой дадлыг нэвтрүүлэн ажиллаж байна.	100.0
71		3.4.2.3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг мөшгөн тогтоох нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгон ажиллуулах;	2019 - 2021		Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсэн байна.	МЭЕГ-аас Мал эмнэлгийн нэгдсэн системийг улс орон даяар бүрэн нэвтрүүлсэн. МЭЕГ-ын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг хүнсний зах, худалдааны төв, супермаркетад магадлан шинжилгээний QR код бүхий цахим гэрчилгээ нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилж, ажлын удирдамж баталсан. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/94 дүгээр тушаалаар "Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох заавар", "Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний бичилтийн цахим загвар", "Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээний хэвлэмэл загвар" тус тус батлан мөрдүүлж байна. Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээг улсын хэмжээнд 70 гаруй хүнсний зах, худалдааны төвд нэвтрүүлж 2021 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар 38584 МШГ-г мал эмнэлгийн нэгдсэн системээр олгоод байна. 2021 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар 29036 тонн мах нийлүүлэгдсэн. Үүнээс: Худалдаанд 20536тн мах, хувийн хэрэгцээнд 238.5тн мах, экспортын зориулалтаар 2695.1тн мах, төхөөрөх зорилгоор нийт 138592 толгой мал, шилжилт хөдөлгөөнөөр тэмээ 439 толгой, адуу 23129 толгой, үхэр 4424 толгой, хонь 5004 толгой, ямаа 15500 толгой, гахай 817 толгой, тахиа 10456 толгой 660.51тн ноос хяналт хийж хүнсний аюулгүй байдлын шаардлага хангуулж ажилласан.	100.0
72	3.4.3.а. Экспортын зориулалттай махны үйлдвэрийг түшиглэн	3.4.3.1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын Үүд боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламжыг байгуулах,	2019 - 2021		Гоц халдварт өвчний гаралт буурна	Хилийн боомт дээр Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын дагуу МХЕГ /ГЕГ/ амьтан, ургамлын хорио цээрийн асуудлыг хариуцан ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд Сэлэнгэ, Дорноговь аймгийн төвд хил дамжин халдварлах мал, амьтны халдварт өвчнийг оношлох лабораторийн барилгын ажил 80%-тай байна. Ажлын гүйцэтгэлд МЭЕГ-аас хяналт тавин ажиллаж байна.	90.0

	худалдааны хорио цээрийн шаардлагад нийцсэн мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламжийг байгуулах;	шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;					
73		3.4.3.2. Өмнөговь, Хөвсгөл аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;	2019 - 2021			Хилийн боомт дээр Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын дагуу МХЕГ /ГЕГ/ амьтан, ургамлын хорио цээрийн асуудлыг хариуцан ажиллаж байна.	-
74		3.4.3.3. Сүхбаатар, Дорнод аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;	2019 - 2021			Хилийн боомт дээр Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын дагуу МХЕГ /ГЕГ/ амьтан, ургамлын хорио цээрийн асуудлыг хариуцан ажиллаж байна.	-
75	3.4.3.б. Мал, амьтны дотоодын шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах;	3.4.3.1. Хулгайн болон албан ёсны зөвшөөрлөөр агнаж байгаа Зэрлэг ан, амьтдыг шинжилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	2019 - 2021			Засгийн газрын 2019 оны 439-р тогтоолын хүрээнд тусгай зориулалтаар агнах болон барихаар зөвшөөрөл хүсэгчтэй байгуулж буй гэрээнд тухайн харьяалах Мал эмнэлгийн байгууллагатай хамтран лабораторийн шинжилгээнд хамруулах хүсэлтийг МЭЕГ-аас БОАЖЯ-д хүргүүлж хамтран ажиллаж байна. ХХААИС-ийн МЭС-тай хамтран зэрлэг гахайд гахайн африкийн мялзан болон бусад халдварт өвчнийг илрүүлэх тандалт, судалгааг гүйцэтгэж байна. Хулгайн болон албан ёсны зөвшөөрлөөр агнаж байгаа зэрлэг ан, амьтдын дээжинд УМЭАЦТЛ экспорт, импорт, оношилгоо, тандан судалгааны зорилгоор шинжилгээ, оношилгоо гүйцэтгэж байна. 2021 онд экспортын зорилгоор нийт 5 аргаль, 8 буга, 23 шувуу, 17 тэх, 40 угалз, 2 зээр, 1 бүргэд 1, оношлогооны зорилгоор 1 туулай , 2 ангир, 8 зээр, 1 дорго, 1 зэрлэг гахай, 2 хар сүүлт, 4 минж, 1 баавгай , тандалт судалгаанд 1 зэрлэг гахайд шинжилгээ хийв. Эмгэг анатомын бүрэн задланг (минж, баавгай, адуу, хурга, тахиа, хондон ангир, цахлай, хулгана, ишиг) зэрэг 9 төрлийн амьтанд гүйцэтгэв. НМЭГ-аас ирүүлсэн 85 минжний цус, арчдасны дээжид тус тус COVID- 19 вирусын генийн өвөрмөц хэсэг (РНХ) илрэв. Мал амьтны гаралтай экспортын түүхий эд, бүтээгдэхүүнд боомын асколийн шинжилгээгээр ангийн арьс (тэх-18, угалз-41, зээр-2, аргаль-5, буга-9)-нд эсрэгтөрөгч илрээгүй. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын хил орчмын хар сүүлт зээрийн дээжинд шүлхий өвчний вирусын генийн хэсэг илрүүлэх, ‘’О’’ хэвшил тодорхойлох шинжилгээг хийж оношлов.	100.0
76	3.4.4. Архангай аймгийн Цахир сумын “Солонготын дабааны ам”, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Гуртын гүүр”,	3.4.4.1. Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, мал, амьтны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах;	2019 - 2021		Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа сайжирч, гоц халдварт өвчний	МЭЕГ-ын даргын баталсан 2021 оны "Малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлт хяналт тавих" 06 тоот нэгдсэн удирдамжийг аймаг, нийслэлийн МЭГ-т хүргүүлж, хяналт тавьж ажилласан. Засгийн газрын 2020 оны “Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг байгуулах байршил тогтоох тухай” 196 дугаар тогтоолоор байгуулагдсан 9 мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын цэг 24 цагаар мал эмнэлгийн улсын байцаагч хяналт тавин ажиллаж, 2021 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар 45719 тээврийн хэрэгслийг хяналт шалгалтад хамруулж адуу 49614 толгой, үхэр 30874 толгой, хонь 269952 толгой, ямаа 120237 толгой, тэмээ 1943 толгой, 44226 тн мах, 18603 мянган литр сүү, 118863 мянган ширхэг өндөг, 597 тн цагаан идээ, 1717 мянган	100.0

	Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Таацын голын гүүр”, Төв аймгийн Лүн сумын “Гүүрний ам”-нд байгуулсан мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг тогтворжуулж, хүний нөөц, техникийн бэлэн байдлыг бэхжүүлэх;				гаралт буурна	ширхэг арьс, шир, 2908 тн ноолуур, 54128 тн ноосыг хяналт шалгалтад хамруулж мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын цэгээр нэвтрүүлсэн байна.	
77		3.4.4.2. Мал эмнэлгийн хяналтын цэгийн тоног төхөөрөмжөөр хангах	2019 - 2021			Дэлхийн банкны МААЭЗЭН төслөөс Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүр, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Архангай аймгийн Цахир сумын төв, Төв аймгийн Лүн сумын Айргийн энгэр дэх МЭХЦХЦэгт компьютер, принтер, ширээ, сандал, халдваргүйтгэлийн багаж, хэрэгсэл, автозамын хаалт, автомашины улсын дугаар уншигч камер зэрэг 140 сая төгрөгийн тоног, төхөөрөмж олгохоор шийдвэрлэж, НҮБ-ын ХХААБ-ын оффиссоос худалдан авалт зарлаж 2021 оны 12 дугаар сард багтаан нийлүүлсэн. Мөн Дэлхийн банкны МААЭЗЭН төсөлд 6 ширхэг явуулын хяналтын цэгийн байр, халдваргүйтгэлийн автомашин шаардлагатай байгаа талаар танилцуулга хүргүүлж, МААЭЗЭН төслийн 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар ярилцаж байна.	100.0
78	3.5.1. Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлж тогтмолжуулах;	3.5.1.1. Мэргэжлийн зөвлөлийг харьяа байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөллийн оролцуулан байгуулах;	2019 - 2021		Мал эмнэлгийн салбарт мөрдөж буй хууль, журам, дүрэм, үйлчилгээний нормативын хэрэгжилт сайжирна	Мал эмнэлгийн Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/294 дүгээр тушаалаар мал эмнэлгийн төрийн болон төрийн бус байгуулага, эрдэм шинжилгээ, боловсрол, үйлдвэрлэлийн байгууллагын төлөөлөл оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2019 онд нэг, 2020 онд нэг удаа хуралдаж шийдвэр гаргасан.	100.0
79		3.5.1.2. Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулах;	2019 - 2021			ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-294 дүгээр тушаалаар "Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг баталсан. Мэргэжлийн зөвлөл нь 2019 онд 1, 2020 онд 1 удаа тус тус хуралдсан.	100.0
80		3.5.1.3. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангах;	2019 - 2021			Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөл 2021 онд 2 удаа хуралдаж Мал эмнэлгийн төлөвлөгөөт дархлаажуулалт, тандалтын 2021 оны төлөвлөгөөг хэлэлцэж, Ерөнхий малын эмчид зөвлөмж өгсөн байна.	90.0
81	3.5.2. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуйг шинээр байгуулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадвартай малын эмч бэлтгэх, давтан сургах;	3.5.2.1. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуй байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021		Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар нэгж байгуулагдан нийт 2500 малын эмчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн байна.	БНСУ-ын Засгийн газрын тусламжаар 2019-2023 онд хэрэгжих Мал эмнэлгийн клиник байгуулах төслөөр клиникийн 950 $м^2$ талбай бүхий барилга барих, тоног төхөөрөмж, суудлын авто машин, нийлүүлэх боловсон хүчний чадавхыг дээшлүүлэхэд хамтран ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар барилга угсралтын явц 70 хувьтай байна.	100.0
82		3.5.2.2. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуйн төвийг түшиглэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 2500 малын эмчид төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах;	2019 - 2021			Дотоодын мэргэшүүлэх 5 төрлийн сургалтад 1590, гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан уулзалт сургалтад 151 эмч, мэргэжилтэн, төслийн болон хамтран ажилладаг байгууллагуудын уулзалт хэлэлцүүлэгт 690 гаруй эмч, мэргэжилтэн хамрагдсан. Мал эмнэлгийн ерөнхий газартай байгуулсан гэрээний хүрээнд Мал эмнэлгийн сургууль нь ШХА-ийн Ногоон алт малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр зайн сургалтын ухаалаг танхим шинээр байгуулж 2021 онд нээж, Монголын мал эмнэлгийн тархварзүйч нарын холбоо ТББ-тай хамтран орон нутгийн тархвар зүйчдэд зориулсан сургалтыг зайн сургалтын танхимаас зохион байгуулсан. Уг танхим нь 180 хүний суудалтай, видео хурлын тоног төхөөрөмж, өргөн	100.0

						нэвтрүүлгийн систем, акустик систем, ухаалаг дэлгэц, их багтаамжтай компьютер, хэвлэх төхөөрөмжөөр тоноглогдсон. Мал, амьтны халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчин, Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, Малын эмийн зохистой хэрэглээ сэдвээр 11 цуврал дижитал гарын авлага, 5 цуврал видео хичээл бэлтгэх ажлыг ШХА-ийн Ногоон алт малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж мэдээллийн санд хүлээн авсан. Жайка төслийн хүрээнд Малын эмчийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, судалгааны төв Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт байгуулагдсантай холбогдон мал эмнэлгийн боловсон хүчний чадавхыг бэхжүүлэн ур чадвартай боловсон хүчин бэлтгэх эхлэл болсон. ШХА-ийн Ногоон алт Малын эрүүл мэнд төслийн хүрээнд төслийн аймгуудын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг дэмжин санхүүжүүлж загвар цогцолборыг байгуулан клиник сургалт зохион байгуулж байна.	
83		3.5.2.3. Малын өвчний тархвар зүйн судалгаа, мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөлтийг хийх сургалтыг зохион байгуулах;	2019 - 2021		1500 малын эмчийг сурган, шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлт хийх нөхцөл бүрдүүлсэн байна.	ШХА-ийн төсөл болон МЭЕГ хооронд 2019 оны байгуулсан 81061564 дугаартай гэрээний хүрээнд Монголын мал эмнэлгийн тархвар зүйч нарын холбоо ТББ-тай хамтран 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн тархвар зүйч нарт зориулсан сургалтыг 2021 оны 3 дугаар сарын 16-19-ны хооронд бүсчлэн цахимаар зохион байгуулав. Цахим сургалтаар нийт 500 гаруй оролцогчоос сургалтын үнэлгээг google form-оор авч нэгтгэв. Мал эмнэлгийн тархвар зүйн тухай ойлголт, тархвар зүйч хандлага, Мал, амьтны өвчний мэдээлэл цуглуулах ба түүний менежмент, Өгөгдөл буюу мэдээллийн тухай ойлголт, Мэдээлэлд анхан шатны дүн шинжилгээ хийх, үр дүнг илэрхийлэх Мал, амьтны өвчлөлийн мэдээнд газар зүйн мэдээлэл (GPS)-ийн ач холбогдол, хэрэглээ, түгээмэл алдаа, Орон нутагт нэвтрүүлэх боломжтой газар зүйн мэдээлэл боловсруулах арга, аргачлал сэдвүүдээр мэдээлэл, дадлага зэрэг агуулгыг багтаасан эпидемиологийн олон эмч, мэргэжилтэнг хамруулсан сургалт болсон. Дэлхийн банкны МААЭЗЭН төслийн хүрээнд Тандалт судалгааны мэдээлэл цуглуулах, мэдээлэлд менежмент хийх сургалтад бэлтгэл ажлыг ханган МЭЕГ, УМЭАЦТЛ, Нийслэлийн мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн хүрээлэнгээс эмч мэргэжилтнийг хамруулав. Мөн энэ төслийн санхүүжилтээр "Зардал үр ашгийн тооцоо хийх арга" сургалтын бэлтгэл хангах уулзалт, сургалтыг 2021 оны 10 сарын 28-ны өдөр зохион байгуулж, ХХААХҮЯ, МЭЕГ, УМЭАЦТЛ, ОБЕГ-ын холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулав. Жайка төслөөс Малын эмч нарын практик чадавх бэхжүүлэх төсөл, УМЭАЦТЛ-той хамтран Тархвар зүйчдийн практик чадавхыг нэмэгдүүлэх онол практик хосолсон сургалтад Нийслэлийн мал эмнэлгийн газрын 8 эмч мэргэжилтнийг хамруулсан.	100.0
84	3.5.3. Мал эмнэлгийн үйлчилгээний анхан шатны түвшинд ажиллах малын эмчийг захиалгаар бэлтгэх,	3.5.3.1. Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнийн тарифыг бүсчлэн тогтоох;	2019		Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, чадавхыг бэхжүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативын төслийг Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2021 оны 118, А-201 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.	100.0
85		3.5.3.2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэг нэгж, малын эмчид ноогдох малын тоог сум, аймаг, бүс нутгаар нь малын төрөл, нас хүйсийг харгалзан тогтоож, мөрдүүлэх;	2019			Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор MNS 5368:2018 стандартыг батлуулан мөрдөж байна. Тус стандартын 7.1.3-т "Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх үед нэг малын эмчийн хариуцах малын тоо хонин толгойд шилжүүлснээр дөчин мянга (40.000)-аас ихгүй байна" гэж заасан байна. Энэхүү шаардлагыг мөрдүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлж байна.	100.0

86	мэргэшүүлэх ажлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамран хэрэгжүүлэх;	3.5.3.3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газар, ШХА-ийн Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл хамтран 15 сумын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 10 нэр төрлийн 11358667 төгрөгийн багаж хүлээлгэн өгсөн. Дэлхийн банкны санхүүжилттэй МААЭЗЭН төслийн хүрээнд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг дэмжих төсөл хэрэгжиж байна.	70.0
87	3.5.4. Лабораторийн ажилтанг мэргэшүүлэх сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах;	3.5.4.1. Мал эмнэлгийн лабораториудын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулах;	2019 - 2021		Төр, хувийн хэвшлийн 2000 гаруй малын эмч, мэргэжилтэн сургалтад хамрагдсан байна.	Мал эмнэлгийн харьяа байгууллага, аймгийн Мал эмнэлгийн газар, “Ногоон алт” ,“Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих” төсөл, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран 40 гаруй хурал, зөвлөгөөн, сургалт, үзэсгэлэн, семинар зохион байгуулж, мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа 4795 малын эмч, мэргэжилтэн хамрагдсан. 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар болон харьяа байгууллагын нийт 80 гаруй малын эмч, мэргэжилтний мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Шанхай, Жилин мужийн Чанчун, Хөх хотод зохион байгуулагдсан “Малын эмийн олон улсын үзэсгэлэн худалдаа”, “Мал, амьтны халдварт өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” олон улсын сургалт, “Хятад-Монголын экспо-3” үзэсгэлэн болон тус улсын эрчимжсэн мал аж ахуйтай танилцах аялалд тус тус хамруулаа. Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан зарим ажлаас: - Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/32 тушаалаар Бодлого судлалын төвтэй гэрээ байгуулан ArcGIS программын аргазүй эзэмшүүлэх сургалтад ХХААХҮЯ, МЭЕГ, УМЭАЦТЛ, НМЭГ болон 21 аймгийн Мал эмнэлгийн газрын эпидемиологич, нийт 33 мэргэжилтэн оролцуулсан сургалтыг Улаанбаатар, Ховд хотод зохион байгуулсан. - Малын эмчид үргэлжилсэн болон итгэмжлэл олгох сургалт зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 110 малын их эмч, 120 малын бага эмчид таван жилийн хугацаатай малын эмчийн итгэмжлэл олгов. - “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн хүрээнд “Мах үйлдвэрлэл-Үйлдвэрлэлийн зохистой дадал” сэдэвт 2 өдрийн сургалтыг аймаг, орон нутгийн махны үйлдвэр, хүнсний захын малын эмч оролцуулан зохион байгуулав. Мал эмнэлгийн лабораториудын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан мал эмнэлгийн салбарын боловсон хүчний сургалт, хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөнд оруулан батлуулав.	70.0
88		3.5.4.2. Гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн мал эмнэлгийн лабораторийн малын эмч мэргэжилтнийг сургах;	2019 - 2021			Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл (МОН-3313)-өөс Улаанбаатар, Дархан хот, Сүхбаатар аймаг, Замын-Үүд, Сайншанд сумдын мал эмнэлгийн лабораторид Хүнсний аюулгүй байдал, Ургамал хамгаалал, Малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр гадаадын зөвлөхөөс бүрдсэн 3 баг сургагч, зөвлөх багш бэлтгэх сургалт зохион байгуулсан. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төсөлтэй хамтран “Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх Дэлхийн 7 хоног” аяны хүрээнд орон нутгийн 160 малын эмчид бичил биетний	100.0

						тэсвэржилтийн тархалт, тэсвэржилт үүсэхээс сэргийлэх арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар цахим семинар зохион байгуулсан. ЖАЙКА ОУБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Малын эмч нарын практик чадавхыг бэхжүүлэх төслөөс "Эмгэг анатомийн задлан шинжилгээ, дээж авах, хадгалах болон лабораторид илгээх практик чадавхыг дээшлүүлэх" сургалтыг Төв аймгийн Аргалант, Алтанбулаг, Зуунмод болон Сэргэлэн сумдын малын эмч нарт цахимаар болон практик дээр зохион байгуулсан. Европын Холбооны санхүүжилтээр ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ болон НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECiMC2)” төслийн хүрээнд “Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ба ДМАЭМБ-ын шаардлагууд” сэдэвт сургагч багш чадавхжуулах олон улсын сургалтыг хүнсний (ялангуяа мах, сүү) үйлдвэрлэлийн салбарын сургалт хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан 5 өдрийн цахим сургалт зохион байгуулж төр, хувийн хэвшил, төрийн бус, мэргэжлийн холбоо, судалгаа, хөгжил, их дээд сургуулийн 100 гаруй төлөөлөл оролцлоо.	
89		3.5.4.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийг түшиглэн хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжийн малын эмч нарыг сургах;	2019 - 2021			JICA MJVET Малын эмч нарын практик чадавх бэхжүүлэх төслийн хүрээнд 2021 онд Нийслэлийн мал эмнэлгийн газрын шинжлэгч эмч нар болон Мал эмнэлгийн сургуулийн багш нарын хамтарсан “Хүнсний хордлого үүсгэгч нянгуудыг илрүүлэх, мах сүүний ариун цэврийн хяналт” сэдэвт сургалт зохион байгуулагдлаа. Сургалтаар хүнсний хордлого үүсгэгч бактериудыг бүтээгдэхүүнээс илрүүлэх, махны магадлан шинжилгээ, сүүний чанарын шинжилгээ сэдвүүдээр онол, лабораторийн дадлага хосолсон явагдсан. Аймгийн мал эмнэлгийн лаборатори болон Нийслэлийн хүнсний зах, худалдааны төвийн дэргэдэх лабораторийн нийт 70 гаруй шинжлэгч эмч цахимаар сурч, лабораторийн дадлага сургалтад хүнсний зах, худалдааны төвийн дэргэдэх лабораторийн 24 шинжлэгч эмч оролцон, шинжилгээний арга зүйг эзэмшиж мэргэжил дээшлүүллээ. “Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох заавар”-ын хүрээнд магадлан шинжилгээний цахим гэрчилгээний системийг Дижитал Медик ХХК хөгжүүлж МЭНС-д байршуулж, хэрэглээнд нэвтрүүллээ. Мал эмнэлгийн магадлан шинжилгээний цахим системийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн томоохон зах худалдааны төв, Мал эмнэлгийн газар, 330 сумын Мал эмнэлгийн тасгийн байцаагч, малын эмч, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, нарыг оролцуулсан алсын зайны цахим сургалтыг 550 хүнд зохион байгуулав.	100.0
90		3.5.4.4. Аймаг, нийслэл дэх төвлөрсөн худалдааны захын мал эмнэлгийн лабораторийн эмч мэргэжилтнийг сургах;	2019 - 2021			JICA MJVET Малын эмч нарын практик чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд 2021 онд Нийслэлийн мал эмнэлгийн газрын шинжлэгч эмч нар болон Мал эмнэлгийн сургуулийн багш нарын хамтарсан “Хүнсний хордлого үүсгэгч нянгуудыг илрүүлэх, мах сүүний ариун цэврийн хяналт” сэдэвт сургалт зохион байгуулагдлаа. Сургалтаар хүнсний хордлого үүсгэгч бактериудыг бүтээгдэхүүнээс илрүүлэх, махны магадлан шинжилгээ, сүүний чанарын шинжилгээ сэдвүүдээр онол, лабораторийн дадлага хосолсон хэлбэрээр явагдсан. Аймгийн мал эмнэлгийн лаборатори болон Нийслэлийн хүнсний зах, худалдааны төвийн дэргэдэх лабораторуудын нийт 70 гаруй шинжлэгч эмч нар цахимаар сургалт авч, лабораторийн дадлага сургалтад хүнсний зах худалдааны төвийн дэргэдэх лабораторийн 24 шинжлэгч эмч оролцон, шинжилгээний арга зүйг эзэмшиж мэргэжил дээшлүүллээ. “Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох заавар”-ын хүрээнд магадлан	70.0

						шинжилгээний цахим гэрчилгээний системийг Дижитал Медик ХХК хамтран хөгжүүлж МЭНС-д байршуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Мал эмнэлгийн магадлан шинжилгээний цахим системийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн томоохон зах худалдааны төв, Мал эмнэлгийн газар, 330 сумын Мал эмнэлгийн тасгийн байцаагч, малын эмч, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, нарыг оролцуулсан алсын зайны цахим сургалтыг 550 хүнд зохион байгуулав.	
91	3.2.5. Мал эмнэлгийн лабораторийн ажилтаны цалингийн зэрэглэл, урамшуулалын тогтолцоо бий болгох, тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгаагаар хангах асуудлыг боловсруулж холбогдох яам, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.	3.2.5.1. Мал эмнэлгийн байгууллагын ажилтны цалингийн зэрэглэлийг хууль эрх зүйн хүрээнд тогтоон, холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;	2021			-	Үнэлэх боломжгүй
92	3.6.1. Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлэх;	3.6.1.1. Мал, амьтны эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн тооцооллыг боловсруулах;	2021		Орон нутгийн төсвийн ачаалал буурна	Малын эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилох тухай ажлын хэсгийн тушаалын төслийг ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулж, дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. “Малын эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийгдсэн. 2. Үзэл баримтлалын төслийн анхны хувилбар боловсруулсан. 3. Хуулийн төслийн анхны хувилбар боловсруулсан. 4. Холбогдох даатгалын хуулийн бүтцийн харьцуулсан судалгааг гаргасан.	50.0
93	3.6.2. Малчдад зориулсан мэдээллийг нээлттэй болгох замаар тэдний мэдлэгийг дээшлүүлж, мал эмнэлгийн үйлчилгээнд тавих хэрэглэгчийн хяналтыг	3.6.2.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа малчдын мал сүргийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;	2019 - 2021		Малын эрүүл мэндийн харилцаанд оролцогчдын малын эрүүл мэндийн талаарх мэдлэг дээшилнэ	Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний цахим QR код бүхий гэрчилгээний танилцуулга, үзүүлэх сургалтыг ХХААХҮЯ, МЭЕГ, “E-Mart”, “Баяндэлгэр хүнс” ХХК-тай хамтран E-Mart хүнсний сүлжээ дэлгүүр дээр 2021.05.25-ны өдөр зохион байгуулав. Мал эмнэлгийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээний системийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн томоохон зах, худалдааны төвүүдэд нэвтрүүлж, 2021 оны 12-р сарын 03-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгжүүдэд нийт 38171 ширхэг QR код бүхий цахим гэрчилгээг олгож, хүнсний бүтээгдэхүүнийг улсын хэмжээнд мал эмнэлгийн магадлан шинжилгээний цахим системээр дамжин малын эрүүл мэндийг баталгаажуулах ажлыг сурталчлан таниулах ажлыг хийв.	90.0
94		3.6.2.2. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гарч болох халдварт өвчний хор	2019 - 2021			Мал, амьтны шилжилт хөдөлгөөн мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор МЭНС-ийн модулыг танилцуулах /шинээр суулгаж, хэрэглэгчийн нууц үгийг сэргээх, бааз дахь мэдээг ашиглах, цахим гэрчилгээ бичих,	100.0

	сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх;	хөнөөл, түүнээс сэргийлэх талаар иргэн хуулийн этгээдийг ухуулга, сурталчилгаа, мэдээллээр хангах;				төлөвлөгөө оруулах, дуудлага үйлчилгээ хийх/богино хэмжээний видео киног ШХА-ийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр хийж Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарын нарт цахимаар хүргүүлэв. Мал эмнэлгийн нэгдсэн систем мал, амьтны шилжилт хөдөлгөөний талаар цахим сургалт зохион байгуулж, нийт 670 гаруй малын эмч хамруулсан. Мал эмнэлгийн нэгдсэн систем, мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналт тавих, хэрэгжилтийн талаар МҮОНРТ-ээр богино хэмжээний видео бэлтгэн сурталчлах ажлыг зохион байгуулав.	
95		3.6.2.3. Малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдэд мал эмнэлгийн хууль, дүрэм журмыг сурталчлан, таниулах;	2019 - 2021			Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2 журам, 2 жагсаалт, 2 чиглэл, нийт 6 эрхзүйн баримт бичиг баримт батлуулан Мал эмнэлгийн салбарт мөрдөж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар батлуулах 24 эрхзүйн баримт бичгээс 19 журам, 1 жагсаалт, 1 норматив, 1 төлөвлөгөө боловсруулж батлуулсан. 2 төлөвлөгөө, 1 журам батлуулах шатандаа байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргаар батлуулах 90 эрх зүйн баримт бичгээс 2 журам, нийтээр мөрдөх 4 заавар, дүрэм 1, стандарт 1, шаардлага 1, жагсаалт 1, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 72 зааврааас 71 заавар, загвар 2, төлөвлөгөө 4, аргачлал 1 эрхзүйн баримт бичгийг батлуулан, мөрдөж байна. Нийт 120 эрх зүйн акт баримт батлуулахаас 115 акт батлагдаж, 5 акт батлуулах шатандаа байна. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд оруулсан алдаатай заалтуудыг залруулахаар 71 өвчний тэмцэх зааврыг 5 ангилж өвчин тус бүрээр нөлөөллийн шинжилгээний тайлан, танилцуулга бэлтгэн Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдэд мал эмнэлгийн хууль, дүрэм журмыг сурталчлан таниулахаар мал эмнэлгийн газартай хамтран ажиллаж байна. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн тухай дүрмийн төсөл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 21 аймаг, нийслэлээс авч нэгтгэн холбогдох газарт хүргүүлэв.	100.0
96	3.6.3. Мал, амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	3.6.3.1. Гоц халдварт өвчний чиглэлээр;	2019 - 2021		Хэвлэл мэдээлэл, цахим хэлбэрээр олон нийтийг 2 удаа, жил бүр 1000 малчныг сургалтад хамруулсан байна.	Гахайн африк мялзан өвчний гарын авлага, нугалбар 3000 ширхэг, Үхрийн арьс товруутах өвчний гарын авлага болон онлайн сэрэмжлүүлгийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, малчид иргэдийн анхаарах асуудлын талаар МҮОНТВ-д 2 удаа ярилцлага өгсөн. Монгол улсад 2021 онд гарсан гоц халдварт өвчний чиглэлээр танилцуулга, гарын авлага бэлтгэн аймаг, сумын Мал эмнэлгийн байгууллагаар дамжуулан цахим мэдээллийн системээр малчид, иргэд орон нутгийн малын эмч нарт мэдээлэл хүргэсэн. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр хийгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн шторкыг тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийн фейсбүүк, пэйж хуудсаар олон нийтэд хүргэж, 500 000 гаруй хандалт авсан байна.	100.0
97		3.6.3.2. Малаас хүнд дамжин халдварладаг өвчний чиглэлээр;	2019 - 2021			Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээг улсын хэмжээнд 70 гаруй хүнсний зах, худалдааны төвд нэвтрүүлж Магадлан шинжилгээний гэрчилгээ олгож, хэрэглэгчдэд анхны гарал үүслийг алдагдуулахгүй хүргэх болсныг сурталчлах зорилгоор Е-март худалдааны төвд НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр нээлтийн арга хэмжээг зохион байгуулж МҮОНТВ-ээр "Эрүүл мал-Монголын баялаг" захиалгат нэвтрүүлгийн 7 дугаар сарын тусгай дугаар ыг олон нийтэд хүргэсэн. Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар, зөвлөмжийг иргэд, олон нийтэд хүргэхээр Монгол малчин сэтгүүл жилийн турш 32 нүүр, Нар импайр медиа групп ХХК www.tand.mn сайттай 30 мэдээ, мэдээлэл, нийтлэл нийтлүүлэх 4 сар,	90.0

						Супервижн медиа групп SBN телевизтэй, Намрын ногоон өдрүүд арга хэмжээнд ашиглагдах танилцуулгын видео контент 10 минут хийлгэхээр тохиролцож, нийт 4 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан. ЭМЯ, ЗӨСҮТ, ХӨСҮТ-тэй хамтран 2019 онд 3, 2021 онд 1 удаа хурлыг зохион байгуулж бэтэг, бруцеллёз, галзуу өвчинтэй тэмцэх чиглэлээр сургалт болон, шторкийг гаргаж цахимд байршуулсан. 2020 онд Хөвсгөл, Булган, Завхан, Сэлэнгэ, Орхон аймгийн хүн, мал эмнэлгийн мэргэжилтнүүдэд МЭХ, ЗӨСҮТ-тэй хамтран боом өвчнийг оношлох, тэмцэх сэдэвт сургалт хийсэн. Мөн 21 аймаг, нийслэлийн МЭГ-ын шимэгч судлаач мэргэжилтнүүдэд 2021 онд шимэгч өвчнийг тандах, илрүүлэх сэдэвт сургалтыг ЗӨСҮТ-д зохион байгуулсан	
98		3.6.3.3. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний чиглэлээр;	2019 - 2021			Гахайн африк мялзан өвчний гарын авлага, нугалбар 3000 ширхэг, Үхрийн арьс товруутах өвчний гарын авлага болон онлайн сэрэмжлүүлгийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, малчид, иргэдийн анхаарах асуудлын талаар МҮОНТВ-д 2 удаа ярилцлага өгсөн. Монгол улсад 2021 онд гарсан гоц халдварт өвчний чиглэлээр танилцуулга, гарын авлага бэлтгэн аймаг, сумын Мал эмнэлгийн байгууллагаар дамжуулан цахим мэдээллийн системээр малчид, иргэд орон нутгийн малын эмч нарт хүргүүлсэн.	100.0
99	3.6.3. Мал, амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	3.6.3.4. Шимэгчтэх өвчний чиглэлээр;	2019 - 2021			Орон нутгийн малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын шимэгчтэх, халдваргүй өвчин хариуцсан мэргэжилтнүүдийн дунд шимэгчтэх өвчний талаар илтгэлийн уралдааныг онлайнаар зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт нийт 21 аймаг, нийслэлийн 35 мэргэжилтэн оролцоноос гадна Мал эмнэлгийн хүрээлэнгийн Хачиг, шавьж, эгэл биетэн судлалын лабораторийн эрдэмтэн, багш нар, Япон улсын Ямагүчи Их сургуулийн судлаач нар урилгаар оролцож, орон нутгийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөв. Хятад улсын Худалдааны танхимын санхүүжилтээр Хөх нуур мужийн Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран “Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнийг сэргийлэх ба оношлох” сургалтыг 2021 онд зохион байгуулж, орон нутгийн 49 малын эмч, мэргэжилтэн оролцов. Малын өвчний мэдээ, мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлж хэрэгжүүлэх, цахимжуулах зорилгоор орон нутгаас цуглуулж байгаа тоон мэдээний хүснэгтийг боловсронгуй болгож, шимэгчтэх болон халдваргүй өвчин хариуцсан мэргэжилтнүүдэд мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, орон нутгийн түвшинд Google sheet-ийг эзэмшин хэрэглэж байна. Мал угаалгад хамрагдсан малын тоон мэдээг цуглуулахад Google sheet хүснэгтийг нэвтрүүлснээр 7 хоног бүр 333 сумаар мэдээг хялбар аргаар авч нэгтгэж, орон нутагт чиглэл өгч ажиллаж байлаа. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх ажлын хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэж, МЭЕГ-ын вэб хуудас болон "Малчин сэтгүүл"-д нийтэлсэн.	100.0
3.6 дугаар зорилт							**93.3**
Дундаж							**82.7**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ